

"НОГООН БИЧИЛ САНХҮҮ" ББСБ-д зориулсан сургалтын гарын авлага



Зохиогч:

Алтангэрэлийн Одгэрэл / МНБ/
Зоригтийн Оюунцацрал /Ph.D/

АГУУЛГА

| | |
|--|----|
| ТАЛАРХАЛ | 5 |
| ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР | 6 |
| СЭДЭВ 1. ТОГТВОРТОЙ БИЧИЛ САНХҮҮ | 7 |
| 1. ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ОЙЛГОЛТ | 7 |
| 1.1 Дэлхийн тогтвортой хөгжил | 7 |
| 1.2 Монгол улсын тогтвортой хөгжил | 11 |
| 2. ТОГТВОРТОЙ САНХҮҮГИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ | 16 |
| 2.1 Тогтвортой бичил санхүү | 17 |
| 3. ТоС ХӨТӨЛБӨРИЙН ТУХАЙ (ТХЗ, ногоон таксономи) | 19 |
| 3.1 ТоС-ийн 8 зарчим | 21 |
| 3.2 Ногоон таксономи | 22 |
| 4. БИЧИЛ САНХҮҮ | 23 |
| 4.1 Тогтвортой хөгжлийг дэмжихэд санхүүгийн байгууллагын үүрэг хариуцлага | 23 |
| 4.2 Ногоон бичил санхүүжилт гэж юу вэ? | 27 |
| 4.3 Тогтвортой бичил санхүүгийн зарчмууд | 29 |
| СЭДЭВ 2. БИЧИЛ САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ УДИРДЛАГЫН ТОГТОЛЦОО | 35 |
| 2.1 БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГМИЙН УДИРДЛАГЫН, ТҮҮНИЙ ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА | 35 |
| Удирдлагын тогтолцоо | 35 |
| Байгаль орчны өөрчлөлт, түүний нөлөө | 36 |
| 2.2 БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГМИЙН УДИРДЛАГЫН ТОГТОЛЦОО | 39 |
| 2.3 БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГМИЙН УДИРДЛАГЫН ТОГТОЛЦООГ НЭВТРҮҮЛЭХ ҮЕ ШАТ | 43 |
| 2.4 БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГМИЙН УДИРДЛАГЫН ТОГТОЛЦООНЫ ЗОРИЛГО, АЧ ХОЛБОГДОЛ | 44 |
| 2.5 БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГМИЙН УДИРДЛАГЫН ТОГТОЛЦООНЫ БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ | 45 |
| Байгаль орчин, нийгмийн удирдлагын бодлого | 47 |
| БОН-ийн эрсдэлийн удирдлагын журам, процедур | 50 |
| Эрсдэл, түүний байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөөллийг тодорхойлох | 52 |
| БОНУ-н Бүртгэл, Тайлагнал | 62 |



| | |
|--|----|
| сэдэв 3. БАЙГАЛЬ ОРЧНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙГ ҮНЭЛЭХ НЬ | 65 |
| 3.1. БАЙГАЛЬ ОРЧНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙГ ҮНЭЛЭХ ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА | 65 |
| 3.2. БАЙГАЛЬ ОРЧНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙГ ҮНЭЛЭХ АРГАЗҮЙ | 68 |
| АШИГЛАСАН МАТЕРИАЛ | 74 |
| ХАВСРАЛТ | 75 |
| Ногоон индекс 2.0 аргачлалын чанарын үнэлгээний асуулга: | 75 |
| Ногоон индекс 2.0 тоон үзүүлэлт: | 77 |
| Ногоон индекс 2.0 -Үнэлгээний асуулгыг бөглөх удирдамж | 79 |
| Жишээ-Ногоон индексийн тооцоололт | 83 |

ТАЛАРХАЛ

Энэхүү гарын авлагыг Санхүүгийн Зохицуулах Хорооны захиалгаар, Alliance for Financial Inclusion (AFI)-ийн санхүүжилтээр Компанийн Засаглалын Хөгжлийн Төв, СЭЗИС-ийн багш нарын баг 2020 оны 6 дугаар сарын 02-оос 8 дугаар сарын 20-ны хооронд хийж гүйцэтгэсэн судалгааны ажлын үр дүнд тулгуурлан гаргасан билээ.

Судалгааг 263 ББСБ-аас ногоон санхүүжилтийн өнөөгийн нөхцөл байдал, ногоон санхүүжилтийн бүтээгдэхүүн зах зээл дээр гаргахад тулгамдаж буй асуудал, бэрхшээлийг тодорхойлох зорилгоор Бичил санхүүгийн байгууллагын ногоон санхүүжилтийн нөхцөл байдлыг тодорхойлох “Ногоон индекс 2.0” аргачлалыг ашиглан явуулсан. Энэхүү гарын авлага нь Тогтвортой бичил санхүү, Байгаль орчны, нийгмийн эрсдэлийн удирдлагын тогтолцоо, Байгаль орчны гүйцэтгэлийг үнэлэх нь гэсэн 3 бүлгээс бүрдсэн болно. Мөн энэхүү гарын авлага нь ногоон санхүүг хөгжүүлэх, байгаль орчны эрсдэлийг бууруулахад санхүүгийн байгууллагын үүрэг оролцоог нэмэгдүүлэхэд тодорхой хувь нэмэр оруулна нь гэдэгт итгэлтэй байна.

Судалгааны үр дүнг үндэслэн ногоон санхүүг Монгол улсад хөгжүүлэх чиглэлд онолын мэдлэг мэдээллийг ББСБ-уудын мэргэжилтнүүдэд хүргэх зорилго бүхий бүтээгдсэн энэхүү гарын авлагыг гаргасан КЗХТ-ийн судлаач, СЭЗИС-ийн профессорууд З.Оюунцацрал (Ph.D), А.Одгэрэл нартаа талархаж байгаага илэрхийлье. Мөн судалгааны багийн гишүүн Б.Ариундалай болон СЗХ-ны Гадаад Харилцаа, Хамтын Ажиллагааны Газрын дарга В.Энхбаатар, мэргэжилтэн М.Долгоржав, Ж.Агиймаа болон СЗХ-ны ББСБ-ийн газрын дарга Б.Итгэлсүрэн, ББСБ-н газрын референт Н.Баярсайхан, Хяналт шалгалт, зохицуулалтын газрын ахлах зөвлөх А.Баянмөнх, мэргэжилтэн нарт судалгааны ажлыг амжилттай явуулах нөхцлийг хангаж, дэмжин ажилласанд талархаж буйгаа илэрхийлье.

Компанийн Засаглалын Хөгжлийн Төв
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Т.ЦЭНД-АЮУШ (Ph.D)



ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

| | |
|---------|--|
| ОУСК - | Олон улсын санхүүгийн корпораци |
| ТоС - | Тогтвортой санхүү |
| НҮБ - | Нэгдсэн үндэсний байгууллага |
| ТХЗ - | Тогтвортой хөгжлийн зорилт |
| БОНУТ - | Байгаль орчин, нийгмийн удирдлагын тогтолцоо |
| БОНЭ - | Байгаль орчин, нийгмийн эрсдэл |
| БОН - | Байгаль орчин, нийгэм |
| ЖДААН - | Жижиг, дунд аж ахуйн нэгж |
| ББСБ - | Банк бус санхүүгийн байгууллага |
| ТУЗ - | Төлөөлөн удирдах зөвлөл |
| БСБ - | Бичил санхүүгийн байгууллага |

ТОГТВОРТОЙ БИЧИЛ САНХҮҮ

Энэ сэдвийн хүрээнд дараах зүйлсийн талаар судлах болно. Үүнд:

- Тогтвортой хөгжлийн ойлголт
 - Дэлхийн Тогтвортой хөгжил
 - Монгол улсын тогтвортой хөгжил
- Тогтвортой санхүү
- ТоС-н хөтөлбөрийн тухай (ТХЗ, ногоон таксономи, замын зураглал)
- Бичил санхүү
 - Бичил санхүүгийн тухай ойлголт
 - Бичил санхүү ба санхүүгийн хүртээмж
- Тогтвортой бичил санхүү
 - Ногоон бичил санхүүжилт гэж юу вэ?
 - Ногоон бичил санхүүжилт яагаад чухал вэ?
 - Байгаль орчин уур амьсгалын өөрчлөлтөөс үүсэх эрсдэл ?
 - Ногоон бичил санхүү нь Тогтвортой хөгжлийн зорилтуудтай хэрхэн уялдах вэ?

1. ТОГТВОРТОЙ БИЧИЛ САНХҮҮ

1.1 Дэлхийн тогтвортой хөгжил

2012 онд Рио Де Жанейро хотод болсон НҮБ-ын чуулганы үеэр анхны санаачилга гарч, 2014 оны 7-р сарын 19-ны өдөр “Тогтвортой хөгжлийн зорилт”-ын нээлттэй ажлын хэсэг НҮБ-ын Ерөнхий Ассамблейн чуулганд дэлхийн тогтвортой хөгжлийн 169 асуудлыг хөндсөн 17

зорилт бүхий удирдамжийг танилцуулж, 2016 оны 1-р сарын 1-нээс “Тогтвортой хөгжлийн зорилго” (ТХЗ) албан ёсоор дэлхий нийтээр хэрэгжиж эхэлсэн. Улмаар эдгээр зорилгууд нь дэлхийн ядуурал, өлсгөлөнг зогсоох, эрүүл мэнд болон боловсролыг дээшлүүлэх, хотуудын тогтвортой байдлыг хангах, уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг тэмцэх, ой далай тэнгисийг хамгаалах гэх мэт олон асуудлуудыг хөндсөн байдаг. 2015 оны 9 дүгээр сарын 25-27-ны өдрүүдэд Нью-Йорк хотноо “Тогтвортой хөгжлийн 2030 хөтөлбөр”-ийг батлах НҮБ-ын дээд хэмжээний уулзалт болж, 193 орны удирдагчид тус хөтөлбөрийг баталсан.

“Тогтвортой хөгжил - 2030 хөтөлбөр” -ийн гол онцлог нь 17 зорилго, 169 зорилтын хэрэгжилтийг хянах индикаторуудыг НҮБ-ын Статистикийн Комиссоос батлан гаргасан асуудлыг шийдэхэд чиглэгджээ. Улс орон бүр өөр өөрсдийн нөхцөлд нийцүүлэн үндэсний индикаторуудыг хөгжүүлэх боломжтой бөгөөд бодит байдалтайгаа нийцүүлэх нь илүү үр дүнтэй хэмээн НҮБ-аас зөвлөсөн байдаг. 2030 он хүртэл жил бүр дээд түвшний уулзалтууд явагдаж, гол асуудал, сорил бэрхшээлүүдээ хэлэлцэж, тоон үзүүлэлтүүдийг нэгтгэн дүгнэсэн явцын тайлангуудыг тогтмол мэдээлдэг байна. Улс орон бүр өөрийн онцлогоос хамаарч аль зорилгыг, ямар дарааллаар хэрэгжүүлэх, хаана илүү анхаарал хандуулахыг тухайн улсын Засгийн газар хариуцаж ажиллахаар үүрэг болгосон байна.

Зураг 1. Тогтвортой хөгжлийн зорилтууд



Эх сурвалж: United Nations Development Program, Sustainable Development Goals, 2015

Тогтвортой хөгжлийн хөтөлбөрийн зорилгууд нь:

1. Бүх хэлбэрийн ядуурлыг зогсоох
2. Тогтвортой хөдөө аж ахуйг дэмжин, хүнсний тэжээллэг чанар, аюулгүй байдлыг нэмэгдүүлэх, өлсгөлөнг зогсоох
3. Бүх насны хүмүүсийн эрүүл аж төрөх байдлыг хангах
4. Боловсрол эзэмшилт, боловсролын чанарыг нэмэгдүүлэх
5. Жендерийн эрх тэгш байдлыг хангах, охид эмэгтэйчүүдийн эрхийг нэмэгдүүлэх
6. Баталгаат ундны ус, ариун цэврийн байгууламжаар хангах
7. Найдвартай, тогтвортой, орчин үеийн сэргээгдэх эрчим хүчийг нэвтрүүлэх
8. Эдийн засгийн өсөлтийг дэмжих, баталгаат ажлын байрыг бий болгох
9. Тогтвортой дэд бүтэц, үйлдвэрлэл, инновацийг дэмжих
10. Тэгш бус байдлыг бууруулах
11. Ээлтэй хот, иргэдийн оролцоог дэмжих
12. Хариуцлагатай хэрэглээ, тогтвортой үйлдвэрлэлийг дэмжих
13. Уур амьсгалын өөрчлөлтийн үр нөлөөг багасгах
14. Далай тэнгисийн нөөцийг хамгаалах
15. Ой хээрийг хамгаалж, цөлжилтийн эсрэг тэмцэх, биологийн төрөл зүйлийн хорогдлыг зогсоох, хуурай газрын экосистемийг хамгаалах
16. Энх тайван, шударга ёс бүхий нийгмийг цогцлоох
17. Тогтвортой хөгжлийн төлөөх дэлхийн түншлэлийг бэхжүүлэх

Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлснээр улс орнуудад ядуурал буурч, тэгш бус байдал арилж, уур амьсгалын өөрчлөлтөөс сэргийлэх гэх мэт

олон давуу талыг бий болгож, тухайн улс төдийгүй, дэлхий нийтээрээ тогтвортой хөгжих боломжтой юм. Тиймээс улс, орон бүр тогтвортой хөгжлийн зорилтуудад анхаарал хандуулж, арга хэмжээнүүдийг дэс дараалалтайгаар авч хэрэгжүүлэх шаардлагатай. Энэ нь зөвхөн тухайн улсын засгийн газар, төрийн тэргүүн, төр засгийн хийх ёстой ажил биш бөгөөд тогтвортой хөгжлийн зорилтуудад хүрэхийн тулд хувь хүн, ард иргэдээс эхлээд иргэний нийгэм, олон нийтийн байгууллагууд, компанийн хувь нэмэр ижил түвшинд шаардлагатай юм.

“Тогтвортой хөгжил” гэдэг ойлголт хүн төрөлхний байгаль орчин, нийгэмд үзүүлж буй сөрөг нөлөө улам бүр нэмэгдсэнтэй холбоотойгоор 1980-д оноос үүссэн байна. 2012 оны 6-р сарын 20-22 нд Бразилын Рио де Жанейро хотноо хуралдсан НҮБ-ын хуралдааны (Рио+20) үеэр “Тогтвортой хөгжлийн хөтөлбөр”-ийг анх санаачилж, дэлхий ертөнц, өнөө болон



ирээдүй үеийнхний хувьд эдийн засаг, нийгэм, байгаль орчинд ээлтэй ирээдүйг бий болгох тогтвортой хөгжилд хүрэхийн тулд хэрэгжүүлэх бодит арга хэмжээг тодорхойлсон баримт бичгийг гаргасан. 2015 оны 9 сарын 25 нд НҮБ-ын Ерөнхий ассемблейн 70-р чуулганаар 2030 он хүртэл хэрэгжих “Тогтвортой Хөгжил” хөтөлбөрийг хэлэлцэж баталсан (С.Дашдорж, 2019).

Тогтвортой хөгжил-2030 хөтөлбөр үндсэн 17 зорилго, 169 зорилт, 229 шалгуур үзүүлэлттэйгээр анх батлагдсан бөгөөд 2017 оны Тогтвортой

хөгжлийн 244 шалгуур үзүүлэлтийг тодорхойлоод байна.

Тогтвортой хөгжилийн зорилтууд нь **нийгэм, эдийн засаг, байгаль орчин** гэсэн гурван тулгуурт суурилсан, урт хугацааны хөгжлийн баримт бичиг болон баталдсан ба дэлхий нийтээр 2016 оны 1 сарын 1 нээс хэрэгжиж эхэлсэн байна (С.Дашдорж, 2019).

1.2 Монгол улсын тогтвортой хөгжил

“Тогтвортой хөгжлийн зорилт-2030” нь **нийгэм, эдийн засаг, байгаль орчин** гэсэн гурван тулгуурт суурилан тогтвортой хөгжилд хүрэх дэлхийн нийтийн урт хугацааны бодлогын баримт бичиг юм (хороо, 2020).

Зураг 2. Тогтвортой хөгжлийн 3 тулгуур



Зураг 3. Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал



Тогтвортой хөгжлийн зорилтуудыг хангахын тулд хүн төрөлхтөн, эх дэлхий дээрээ нягт хамтран ажилласнаар энх тайван байдлыг бүрдүүлж, хамтдаа хөгжин цэцэглэх боломж бидэнд байгааг харуулж байна.

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монгол улсын тогтвортой хөгжил

Энэ нь нэг хүн, нэг улс орон дангаараа зүтгээд нэмэргүй, дэлхий дээр байгаа бүх хүн, бүх улс орон хамтдаа нэгдэж, хамтарч чадвал бүгд хамтдаа хөгжих тухай асуудал юм. Тиймээс олон талын оролцоо, хүчин чармайлттайгаар хүн төрөлхтөн сайн сайхан аж төрөх боломжтой болох юм.

2016 оны 2-р сард УИХ-ын тогтоолоор Монгол Улсын Тогтвортой



хөгжлийн үзэл баримтлал-2030 (ТХҮБ-2030)-ыг баталсан байна. Дэлхийн ТХЗ-ын 17 зорилго, 169 зорилт нь манай улсын ТХҮБ-2030-ын 4 бүлэг, 44 зорилттой дараах байдлаар уялдаж байгаа юм.

Зураг 4. Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал (2016)

2016 оны 2-р сард УИХ-ын тогтоолоор Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 (ТХҮБ-2030)-ыг баталсан байна. Дэлхийн ТХЗ-ын 17 зорилго, 169 зорилт нь манай улсын ТХҮБ-2030-ын 4 бүлэг, 44 зорилттой дараах байдлаар уялдаж байгаа юм.

Дэлхийн ТХЗ-ын 17 зорилгоос 7 зорилго нь манай улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд зорилго болон тодорхойлогдож, 9 зорилго нь агуулгаараа тусгагдаж, 1 зорилго нь манай улсад шууд хамааралгүй гэж үзсэн байна.

2020 оны 5-р сарын 25 нд УИХ-с баталсан “Алсын хараа 2050”-д агуулгаараа багтсан. Үүнд: Ногоон хөгжилийн талаар баримтлах бодлого зорилгыг “Байгаль орчинд ээлтэй ногоон хөгжлийг эрхэмлэн экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалж, байгаль орчны тогтвортой байдлыг ханган үр өгөөжийг нь өнөө болон ирээдүй хойч үе хүртэх нөхцөлийг бүрдүүлж, хүний амьдралын чанарыг сайжруулна” гэж тусгасан байна. Энэхүү зорилгын хүрээнд хүрэх үр дүнгүүдээс зарим нэгийг дурдвал: Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, тэсвэрлэх чадавхийг бэхжүүлж, үүсэж болзошгүй эрсдэлийг бууруулна.

Төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурласан **ногоон санхүүгийн үндэсний тогтолцоог дэмжин хөгжүүлж, олон улсын санхүүгийн арга хэлбэрийг ашиглан байгальд ээлтэй ногоон төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлнэ.**

Шигтгээ 1: Алсын хараа-2050

Нүүрстөрөгч багатай, бүтээмжтэй, хүртээмжтэй ногоон хөгжил

Зорилт 6.4. Нүүрстөрөгч багатай, бүтээмжтэй, хүртээмжтэй ногоон эдийн засгийг хөгжүүлж, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах олон улсын хүчин чармайлтад хувь нэмэр оруулна.

Зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа

6.4.1. Байгальд ээлтэй, хэмнэлттэй хэрэглээ, үр ашигтай дэвшилтэт **ногоон технологийг эдийн засгийн хөшүүргээр дэмжинэ.**

6.4.4. Бохирдол, хаягдлыг бууруулах, нөөцийн хэмнэлттэй байгальд ээлтэй дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлж, цэвэр үйлдвэрлэл, хэмнэлттэй хэрэглээг эдийн засгийн хөшүүргээр дэмжинэ.

6.4.5. Байгаль орчны менежментийн MNS ISO14000 багц стандарт нэвтрүүлэх, ногоон гэрчилгээ олгох тогтолцоог дэмжин эрчимжүүлж, үйлдвэрлэл, хэрэглээний зөв дадлыг бий болгоно.

6.4.6. Төрийн худалдан авалтыг ногоон худалдан авалтад үе шаттайгаар шилжүүлж, хувийн хэвшлийг дэмжих тогтолцоог бүрдүүлнэ.

6.4.7. Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлж, Монгол Улсын тодорхойлсон хувь нэмэр (NDC) баримт бичгийн хэрэгжилтийг хангаж, сэргээгдэх эрчим хүчийг хөгжүүлэн, эрчим хүч, хөдөө аж ахуй, барилга, тээвэр, аж үйлдвэр, хог хаягдлын салбарын хүлэмжийн хийн ялгарлыг бууруулна.

6.4.8. Ойжуулах, хүлэрт намгийг хамгаалах, эвдэрсэн газрыг нөхөн сэргээж ургамлын нөмрөгийг хамгаалах, ургамалжуулах замаар хүлэмжийн хийн шингээлтийг нэмэгдүүлнэ.

6.4.9. Салбаруудын хүлэмжийн хийн ялгарлыг хэмжих,

тооцоолох, тооллого хийх, магадлах, тайлагнах чадавхийг бий болгон бэхжүүлж, цахимжуулна.

6.4.10.Барилгын салбарт ногоон, эрчим хүчний хэмнэлттэй бүтээгдэхүүн үйлдвэрлэгч дотоодын үйлдвэрүүдийг дэмжин хөгжүүлнэ.

6.4.11.Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох үндэсний хөтөлбөрийг баталж, хэрэгжилтийг хангана.

6.4.12.Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй эрсдэлийн даатгалын тогтолцоог судалж бүрдүүлнэ.

6.4.13.Байгаль, цаг агаарын аюулт үзэгдлийг урьдчилан мэдээлэх, сэрэмжлүүлэх чадавхийг бэхжүүлж, таваас доошгүй байршилд радарын станц байгуулна.

6.4.14.Байгальд ээлтэй ногоон төсөл, үйл ажиллагааг санхүүжүүлэх төр, хувийн хэвшлийн хамтарсан үндэсний ногоон санхүүгийн тогтолцоог байгуулж хөгжүүлнэ.

6.4.15.Байгаль орчинд ээлтэй тогтвортой санхүүгийн тогтолцоог бэхжүүлж, тогтвортой бизнесийн зарчмыг эдийн засаг, нийгмийн салбарт нэвтрүүлж, аж ахуйн нэгжийн байгаль орчин, нийгмийн хариуцлагыг өндөржүүлнэ.

6.4.16.Байгальд ээлтэй тогтвортой үйлдвэрлэлийг хөгжүүлэх, ухаалаг хэрэглээг төлөвшүүлж дэлгэрүүлэх, байгаль орчин, нийгэмд ээлтэй төсөл, үйл ажиллагааг санхүүжүүлэх үндэсний ногоон санхүүгийн тогтолцоо (ногоон банк, ногоон бонд, ногоон бирж, ногоон даатгал)-г шинэ шатанд гаргана.

6.4.17.Нэгдсэн Үндэстний Байгууллагын уур амьсгалын ногоон сан болон бусад олон улсын санхүүгийн арга хэлбэрээр дамжуулан сэргээгдэх эрчим хүчийг хөгжүүлэх, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, хаягдлыг багасгах, нөөцийн ашиглалтын үр ашгийг нэмэгдүүлэх ногоон төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

Үндэсний статистикийн хороо (ҮСХ)-ноос “Тогтвортой хөгжлийн зорилт”-ыг хангасан байдлыг ТХЗ-ын шалгуур үзүүлэлтийн¹ дагуу 2015-2017 онд урьдчилсан байдлаар үнэлсэн байна. Үнэлгээний үр дүнгээс 2014 онтой харьцуулахад 2016 онд Ядуурлыг устгах, Өлсгөлөнг зогсоох, Чанартай боловсролыг дэмжих, Зохистой хөдөлмөр ба эдийн засгийн өсөлтийг дэмжих зорилгын хүрээнд эерэг өөрчлөлтүүд гараагүй, голлох үзүүлэлтүүд буурсан хандлагатай байна. Мөн Эрүүл мэндийг дэмжих, Жендерийн эрх, тэгш байдлыг хангах чиглэлд улс төр дэх эмэгтэйчүүдийн оролцооноос өөрөөр бүртгэл бараг хийгддэггүй, эмэгтэйчүүдийн оролцоо нэмэгдээгүй, Баталгаат ундны ус, ариун цэврийн байгууламжаар хангах, Сэргээгдэх эрчим хүчийг нэвтрүүлэх чиглэлд өөрчлөлт ажиглагдаагүй байна. Харин Инноваци болон дэд бүтцийг хөгжүүлэх чиглэлд ачаа тээвэр өссөнөөс бусад үзүүлэлт буурах хандлагатай, Тэгш бус байдлыг бууруулах чиглэлд гадаадын шууд хөрөнгө оруулалт, гадаад зээл тусламж өссөн бусад үзүүлэлтүүд өөрчлөлтгүй байгаа бол Ээлтэй хот, иргэдийн оролцоог дэмжих, Хариуцлагатай хэрэглээг дэмжих, Уур амьсгалын өөрчлөлтийн үр нөлөөг багасгах, Хуурай газрын эко системийг хамгаалах чиглэлд бага зэрэг эерэг өсөлтүүд байгаа хэдий ч ихэнх үзүүлэлтүүд өөрчлөлтгүй байна. Энх тайван, шударга ёсыг цогцлоох, Хөгжлийн төлөөх түншлэлийг бэхжүүлэх чиглэлд эерэг өсөлттэй байгааг харж болохоор байна.

Эдгээр нь манай улс ТХЗ-уудаа 2016 онд тодорхойлох үеийн үр дүнгүүд гэдгийг анхаарах хэрэгтэй. ТХЗ-2030-ийн хүрээнд 2016-2020 онд хэрэгжүүлэх ажлуудыг төлөвлөснөөр 2016 оныхтой харьцуулахад өнөөгийн нөхцөл байдлын үр дүнг сайжирсан байх гэсэн хүлээлттэй байж болохоор байна. Учир нь улсын хэмжээнд ТХЗ-уудыг баталсан, үүний хүрээнд нилээд ажлууд төлөвлөгдсөн, банкууд ТоС хөтөлбөрийн хүрээнд өргөн хүрээтэй ажлууд хийж байна. Гэхдээ эдгээр ажлуудын үр дүн богино хугацаанд үр дүнгээ өгөх ажлууд ч байгаа, нэлээд урт хугацааны дараа үр дүнгээ өгөх ажлууд ч байна.

Дэлхийн ч бай, манай улсын ч бай эдгээр тогтвортой хөгжлийн зорилго, зорилтуудыг хангахад санхүүгийн асуудал нэн тэргүүний шийдвэрлэх асуудал болоод байна. Тиймээс эдийн засгийн өсөлтөд дэмжлэг болох, баталгаат ажлын байр бий болгоход санхүүгийн институтуудын оролцоо, дэмжлэг чухал байна. Байгаль орчинд учирч буй хохирол, экосистемийн доройтол болон байгаль орчин, нийгэмд гарч буй

¹ Тогтвортой хөгжлийн зорилтын шалгуур үзүүлэлтийг 2017 оны 3 сард НҮБ-ын Статистикийн комиссын 48-р чуулганаар ТХЗ-ын хэрэгжилтийг дүгнэх 244 шалгуур үзүүлэлтийг тодорхойлсон байна.




өөрчлөлтүүд нь дэлхийн хэмжээнд тулгарч буй томоохон сорилт болж байгаа бөгөөд аливаа улсын эдийн засаг болон хөгжлийн гол тулгуур болсон санхүүгийн системээрээ дамжуулан дээрх асуудлыг шийдвэрлэх боломжтой.

2. ТОГТВОРТОЙ САНХҮҮГИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ

Тогтвортой санхүү нь аливаа санхүүгийн шийдвэр гаргалтад байгаль орчин, нийгэм болон засаглалын шалгуур үзүүлэлтүүдийг нэгтгэх тухай асуудал юм. Тухайлбал, тогтвортой санхүү нь ногоон санхүү, уур амьсгалын санхүү дээр нэмэх нь байгаль орчинд ээлтэй, байгаль орчны нөөц хэмнэсэн хэрэглээнээс эхлээд ногоон орчинд болон нийгэмд эерэг нөлөө үзүүлэх хөрөнгө оруулалтын төслүүдийг санхүүжүүлэх асуудал бөгөөд нийгмийн сайн сайхан байдал, байгууллагын засаглал, менежментийн хүчин зүйлсийг тооцдоогоороо илүү өргөн хүрээг хамардаг.

Тогтвортой санхүүгийн зарчмаар санхүүжүүлэх төсөл нь зөвхөн хөрөнгө оруулагчдад ашигтай байгаад зогсохгүй байгаль орчин, нийгмийн сайн сайхан байдалд хор хохирол учруулахгүй байх ёстой. Энэ нь зохистой засаглалтай байж, хууль журмыг мөрддөг, иргэдийн эрх ашиг, амар тайван байдлыг хангадаг, түүх соёлын дурсгалт зүйлсийг дээдэлдэг, хүний эрхийг дээдэлж, сайн сайхан байдлыг хангадаг байх зарчмуудыг мөрдөнө гэсэн үг юм.

Зураг 5. Монгол улсын тогтвортой санхүүгийн 3 тулгуур



Эх сурвалж: НҮБ-ын Байгаль орчны судалгаа, 2016

НҮБ-ын 2016 онд хийсэн Байгаль орчны судалгааны үр дүнгээр тогтвортой санхүүгээр дамжуулан уур амьсгалын өөрчлөлтийг сааруулж, ногоон байгаль орчныг дэмжсэнээр аливаа улс орны хөгжил цаг зуурын биш, тогтвортой хөгжих боломж байна гэдгийг харуулжээ. Өөрөөр хэлбэл, банк санхүүгийн байгууллагууд зээлийн үйл ажиллагаагаар эдийн засгийн өсөлтөд дэмжлэг болохдоо байгаль орчин, нийгэмд ээлтэй бизнес, иргэдийн үйл ажиллагааг дэмжсэнээр дээрх зорилго, зорилтууд хэрэгжиж, тогтвортой хөгжлийг бий болгох боломжтой юм. Тогтвортой санхүү нь дараах ач холбогдолтой:

- Санхүүгийн байгууллагууд олон улсаас хямд эх үүсвэр татах боломж
- Эрсдэлийн удирдлагын тогтолцоогоо сайжруулах боломж
- Шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ хөгжүүлэх, зах зээлд нэвтрүүлэх боломж
- Шинэ харилцагч, зах зээлээ тэлэх боломж
- Нэр хүнд өсөх

2.1 Тогтвортой бичил санхүү

Тогтвортой бичил санхүү гэдэг нь ердийн банк, санхүүгийн байгууллагаас санхүүгийн үйлчилгээ авч чадахгүй байгаа хувиараа бизнес эрхлэгч, бичил болон ЖДААН-д эдийн засгийн боломж олгох цэвэр, уян хатан, тогтвортой байдлаар үзүүлэх санхүүгийн үйлчилгээ (санхүүгийн үйлчилгээний нэг хэсэг болох санхүүгийн бус үйлчилгээ) юм.

Зураг 6. Тогтвортой бичил санхүүгийн 3 тулгуур





Тогтвортой хөгжлийн зорилтууд нь нийгэм, эдийн засаг, байгаль орчин гэсэн гурван тулгуурт суурилсан, урт хугацааны хөгжлийн баримт бичиг болон батлагдсан ба дэлхий нийтээр хэрэгжиж эхэлсэн байна. Энэхүү зарчмын хүрээнд тогтвортой хөгжлийг хангахын тулд нийгэм нь байгаль орчны тэнцвэрт байдлыг хадгалах, хангах, Эдийн засаг нь нийгэмд тэгш, шударга хуваарилалт хийдэг байх, Эдийн засаг нь байгаль орчинд ээлтэй хөрөнгө оруулснаар оршин тогтнох чадвартай болсноор улс орон тогтвортой хөгжих юм.

Санхүү, эдийн засаг:

- Ядуурал
- Орлогын ялгаатай байдал
- Ажилгүйдэл

Хүн, нийгэм:

- Хүн амын хэт өсөлт
- Хүний эрх
- Хүйсийн эрх тэгш байдал
- Хүнсний аюулгүй байдал
- Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа
- Эрчим хүчний хэрэглээний өсөлт
- Хотжилт, технологийн хөгжлийн сөрөг нөлөө
- Хог хаягдал
- Өлсгөлөн

Байгаль орчин:

- Уур амьсгалын өөрчлөлт
- Экосистемийн доройтол
- Биологийн олон янз байдлын хомсдол

- Байгаль орчны бохирдол
- Цөлжилт
- Байгалийн нөөцийн хомсдол
- Газрын зохисгүй ашиглалт
- Цөмийн хаягдал
- Бохирдол (агаар, ус, хөрс)

3. ТоС ХӨТӨЛБӨРИЙН ТУХАЙ (ТХЗ, ногоон таксономи)

Монгол улсын хувьд 2013 оны 11 дүгээр сард нийт банкууд тогтвортой санхүүжилтийн үзэл баримтлалыг байгаль орчныг хамгаалах, нийгмийн хариуцлагын бодлогоор дамжуулан нэвтрүүлэхийг санал нэгтгэйгээр дэмжиж “Монгол Улсын нийгэм, байгаль орчинд ээлтэй Тогтвортой санхүүжилтийн бодлогыг хөгжүүлэхийн төлөөх хамтарсан тунхаг бичиг”-т гарын үсэг зурж, “Монгол Улсын Тогтвортой Санхүүжилт (ТоС)-ийн хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэхээр шийдвэрлэж байсан. Энэхүү ТоС хөтөлбөрийн хүрээнд нийт банкууд 2015 оноос эхлэн Монгол Улсын Тогтвортой санхүүжилт (ТоС)-ийн зарчмууд болон 5 салбар (уул уурхай, барилга, хөдөө аж ахуй, боловсруулах болон нэхмэлийн салбар)-ын удирдамжуудыг боловсруулсан.

Монголын Тогтвортой Санхүүгийн Холбоо “ТоС Холбоо”-г Монголын Банкны Холбооноос 2017 оны 12 дугаар сард үүсгэн ГҮТББ-ын хэлбэрээр үүсгэн байгуулсан бөгөөд өнөөдөр Монголын банкны салбарт үйл ажиллагаагаа явуулж буй бүх 15 банкиг нэгтгэн үйл ажиллагаагаа явуулж байна.

ТоС Холбоо нь Монгол Улсын санхүүгийн салбар болон бизнесийн байгууллагуудад байгаль орчин, нийгэмд ээлтэй үйл ажиллагааг нэвтрүүлэх, тогтвортой санхүү, ногоон зээл, хөрөнгө оруулалтын дэд бүтэц бүрдүүлж, тогтвортой хөгжил, ногоон эдийн засгийн өсөлтийг дэмжихийг зорьж ажилладаг. Түүнчлэн тогтвортой санхүүтэй холбоотой тулгарч буй асуудлуудад Гишүүдийн үйл ажиллагааг нэгтгэн чиглүүлж, шийдэл боловсруулан, Монгол Улсын байгаль



орчин, нийгэм, эдийн засгийн тэнцвэртэй хөгжилд хувь нэмэр оруулах зорилттойгоор ажиллаж байна.

- Монгол улс Парисын хэлэлцээр, Тогтвортой хөгжлийн зорилтуудад нэгдсэн.
- 2016 оны 2-р сард УИХ-ын тогтоолоор Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 (ТХҮБ-2030)-ыг баталсан.
- 2013 онд Банкууд тогтвортой санхүүгийн үзэл баримтлалыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх санаачлагыг эхлүүлж, МУ-н Тогтвортой санхүүжилтийн хөтөлбөрийг бий болгосон.
- 2014 онд - ТоС-ийн 8 зарчмыг боловсруулж баталсан.
- 2014 онд Уул уурхай, хөдөө аж ахуй, барилга, боловсруулах үйлдвэр гэсэн 4 салбарын удирдамжыг боловсруулж, батлан гаргасан.
- 2015 оноос банкууд БОНУТ-г нэвтрүүлж, зээл олгох болон зээлийн үйл ажиллагааны БОН-ын эрсдэлийн үнэлгээг хийдэг болсон.
- 2019 онд Нэхмэлийн салбарын удирдамжийг боловсруулж, баталсан.
- 2019 онд “Ногоон таксономи” буюу ногоон үйл ажиллагааны ангилал, шалгуурыг баталсан.

Тогтвортой санхүүжилттэй холбоотой боловсруулсан дээрх 5 салбарын удирдамжийг ТоС-ийн 8 зарчимд нийцүүлж, эдгээр зарчмуудын хэрэгжилтийг дэмжсэн байхаар боловсруулсан. Салбарын удирдамжийг хөдөө аж ахуй, барилга, нэхмэл, уул уурхай болон боловсруулах салбарын төслийг санхүүжүүлж, харилцагчдад зээл олгож буй банкуудад зориулсан бөгөөд тэдгээрийн хувьд шинэ харилцагч, төсөл, зээлийн эрсдлийг үнэлэхдээ Монгол Улсын Тогтвортой санхүүжилт (ТоС)- ийн зарчмууд болон энэхүү салбарын удирдамжийг мөрдөхөөр заасан. Хэдий ч эдгээр удирдамж нь банкуудад зориулагдсан боловч ББСБ-уудын хувьд мөн тухайн салбарын харилцагч, зээлдэгчийн БОНЭ-г үнэлэх болон зээлийн олгох эсэх шийдвэр гаргалтандаа удирдамж болгон ашиглах боломжтой юм. Тиймээс ТоС-ийн хөтөлбөрийн хүрээнд боловсруулсан тогтвортой, ногоон санхүүг хөгжүүлэх, БОНЭ-ийг үнэлэхтэй холбоотой баримт бичиг, удирдамжуудыг Монголын Тогтвортой Санхүүгийн Холбооны цахим хуудас /www.toc.mn/-с авч танилцах боломжтой юм.

3.1 ТоС-ийн 8 зарчим

- 1. Байгаль орчноо хамгаалах:** Бид хөрс, ус, агаар, биологийн олон янз байдал, байгалийн сэргээгдэх болон сэргээгдэхгүй шавхагдаж буй нөөцийг хадгалан хамгаалж, тэдгээрт үзүүлэх сөрөг нөлөөллийг бага байхаар тогтвортой ашиглах хандлагыг дэмжин ажиллана.
- 2. Хүний эрх, нийгмийг хамгаалах:** Бид хүний эрхийг хүндэтгэж, хөдөлмөрийн стандартыг мөрдөнө. Иргэдийн эрүүл мэндийг хамгаалж, тэдгээрийн аюулгүй байдлыг ханган ажиллана.
- 3. Соёлын өвийг хамгаалах:** Бид Монгол Улсын түүхэн тодорхой орон зай, цаг үеийг төлөөлөх соёлын онцгой өв болох ёс заншил, хэл, бусад өв, түүнчлэн соёл, түүх, археологи, палентологийн түүх соёлын дурсгалыг хадгалж хамгаалан ажиллана.
- 4. “Ногоон эдийн засаг”-ийн өсөлтийг дэмжих:** Бид Монгол Улсын ногоон, цэвэр эдийн засагт хувь нэмэр оруулах төсөл болон бусад үйл ажиллагааг дэмжин ажиллана.
- 5. Санхүүгийн хүртээмжийг дэмжих:** Бид санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэн, санхүүгийн боловсрол олгох, харилцагч хамгаалагдах баталгааг бий болгох замаар Монгол Улсад санхүүгийн өргөн хүрээтэй тогтолцоог бий болгохыг дэмжин ажиллана.
- 6. Ёс зүйтэй санхүүжилт, компанийн засаглалыг дэмжих:** Бид хориглосон жагсаалтанд багтсан үйл ажиллагааг санхүүжүүлэхгүй, бид ёс суртахуунгүй, гэмт хэргийн шинж чанартай үйлдлийг үл тэвчих бодлого явуулж, ёс зүйтэй байх, компанийн засаглалтай холбоотой сайн туршлагуудыг дэмжих бодлого баримтлан ажиллана.
- 7. Ил тод байдал, хариуцлагыг дэмжих:** Бид ил тод байдал, хариуцлагыг дэмжин, банкны тогтвортой санхүүжилтийн үүрэг хариуцлагын хүрээнд тайлагнах явдлыг дэмжин ажиллана.
- 8. Манлайлан үлгэрлэх:** Бид харилцагчиддаа тавьж буй шаардлагыг өөрийн бизнесийн үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж, салбарын хувьд Монгол Улсыг байгаль орчин, нийгэм, эдийн засгийн хувьд эерэг хөгжилд чиглүүлэн ажиллана.

ТоС-ийн зарчмуудыг агуулгаас нь хамааруулан **хамгаалах, дэмжих, үлгэрлэн манлайлах** гэж 3 ангилдаг.



3.2 Ногоон таксономи

“Ногоон таксономи” нь хүлэмжийн хий, агаар орчны бохирдлыг бууруулах, байгаль орчинд ээлтэй үйл ажиллагааны ангилал, шалгуур үзүүлэлт бөгөөд банк, санхүүгийн байгууллагууд, хөрөнгө оруулагчид, болон бодлого боловсруулагчид энэхүү таксономийг ногоон зээл, хөрөнгө оруулалт оруулах төсөл, хөтөлбөрүүдийг тодорхойлохдоо ашиглах юм. Энэхүү баримт бичгийг ТоС Холбоо, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Монголбанк, Цинхуа их сургууль болон Олон улсын санхүүгийн корпораци (ОУСК) хамтран гаргаж байгаа бөгөөд Монгол Улсын Засгийн газар мөн туслалцаа үзүүлэн яамдууд болоод зохицуулагч, хэрэгжүүлэгч агентлагууд дэмжин оролцож байна.

Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөс Монгол улсын ногоон таксономийг 2019 оны 12 сард баталсан (МБ, СЗХ, СЯ, ХДК, 2019).

Зураг 7. Монгол улсын ногоон таксономи

| МОНГОЛ УЛСЫН НОГООН ТАКСОНОМИ | | | Зах зээл дээрх гол ороллогчид | Ашиглах зориулалтууд (энд дурдсанаар хязгаарлагдахгүй) |
|--|---|---|--|--|
| Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөс 2019 оны 12 дугаар сард батлав | | | Санхүүгийн байгууллагууд (банк, банк бус санхүүгийн байгууллагууд, хөгжлийн банкууд, орон сууцны зээлийн корпорациуд, байгууллагын хөрөнгө оруулагчид, зээлийн баглан даалтын сангууд, даатгалын компаниуд гэх мэт) | <ul style="list-style-type: none"> Ногоон санхүүжилтийн стратеги, бодлого боловсруулах, Ногоон санхүүжилт хийх эсвэл татах боломжит төслүүд, бизнесийн үйл ажиллагааг тодорхойлж, судлах, хөрвүүлэх, Ногоон санхүүжилтийн бүтээгдэхүүний шалгуурыг боловсруулах, Зээлийн багц дахь ногоон санхүүжилтийн урсгалыг хэмжих, тайлагнах, Харилцагч, гол ороллогч талуудын мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, сурах зэрэгт ашиглах |
| ТАНИЛЦУУЛГА | СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧ | БОХИРДОЛ БАГАТАЙ ЭРЧИМ ХҮЧ | | |
| 4 | 12 | 14 | | |
| ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМЖЛЭЛТ | НОГООН БАРИЛГА | БОХИРДЛООС СЭРГИЙЛЭХ, БУУРИУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА | | |
| 15 | 17 | 19 | | |
| ТОГТВОРТОЙ УС, ХАЯГДЛЫН ХЭРЭГЛЭЭ | ТОГТВОРТОЙ ХӨДӨӨ АЖ АХУЙ, ГАЗАР АШИГЛАЛТ, ОЙ БОЛОН ЭКО АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ | КАРБОН БАГА ЯЛГАРУУЛДАГ ТЭЭВЭР | | |
| 20 | 22 | 24 | | |

Эх сурвалж: Ногоон таксономийн танилцуулга, 2019

Ногоон таксономийг дараах үндсэн 6 зарчмын дагуу боловсруулсан:

Зарчим 1: Үндэсний бодлого, зорилтуудыг хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулах

Зарчим 2: Байгаль орчинд тулгарч буй бэрхшээл, асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн байх

Зарчим 3: Байгаль орчинд хог хаягдал, бохирдол ихээр ялгаруулдаг эдийн засгийн гол салбаруудын үйл ажиллагааг хамарсан байх

Зарчим 4: Олон улсын холбогдох стандартууд болон сайн туршлагаудтай нийцсэн байх

Зарчим 5: Байгаль орчин, нийгэм болон сайн засаглалын холбогдох стандартуудыг хангасан байх

Зарчим 6: Байнга хянан сайжруулж байх

Ногоон таксономийн ерөнхий 8 чиглэл:

1. Сэргээгдэх эрчим хүч
2. Бохирдол багатай эрчим хүч
3. Эрчим хүчний хэмнэлт
4. Ногоон барилга
5. Бохирдлоос сэргийлэх, бууруулах үйл ажиллагаа
6. Тогтвортой ус, хаягдлын хэрэглээ
7. Тогтвортой хөдөө аж ахуй, газар ашиглалт, ой болон эко аялал жуулчлал
8. Карбон бага ялгаруулдаг тээвэр

4. БИЧИЛ САНХҮҮ

4.1 Тогтвортой хөгжлийг дэмжихэд санхүүгийн байгууллагын үүрэг хариуцлага

Тогтвортой санхүүгийн тогтолцоо гэдэг нь байгаль орчин, нийгэмтэй холбогдох эрсдэл багатай, засаглал, ил тод байдал сайтай буюу шууд утгаараа тогтвортой өсөлт, хөгжлийг эрхэмлэсэн санхүүгийн тогтолцоо юм. Тогтвортой хөгжлийн тогтолцооны суурийг бэхжүүлэх, хэрэгжилтийг хурдасгахад санхүүгийн хөшүүрэг чухал нөлөөтэй учир банк, санхүүгийн байгууллагууд тогтвортой санхүүжилтийн үзэл баримтлалаар дамжуулан улс орныхоо хөгжлийн явцад хувь нэмрээ оруулах боломжтой байдаг.

Дэлхийн олон улс тогтвортой санхүүжилтийн зарчмуудыг боловсруулж, тэдгээрийг хөрөнгө оруулалт, зээл, санхүүгийн үйл ажиллагаандаа нэвтрүүлэхийг эрмэлзэн ажиллаж байна. ОУСК 43 улсын 120 гаруй

санхүүгийн байгууллагыг хамруулан хийсэн судалгаагаар дараах эрсдэлүүдийг тодорхойлсон байна. Судалгааны үр дүнгээс харахад зээлийн болон нэр хүндийн эрсдэлүүд өндөр хувийг эзэлсэн байна.

Зураг 8. Санхүүгийн байгууллагуудад учирч буй эрсдэлүүд



Зураг 9. Банкууд нийгмийн асуудалд анхаардаг гол шалтгаан



Зураг 5. Монгол улсын тогтвортой санхүүгийн 3 тулгуур

Банкууд нэр хүндээ өсгөх, хөрөнгө оруулагчдыг татах, оролцогч талуудын үнэ цэнийг нэмэгдүүлэх зорилгоор хүрээлэн буй орчин, нийгмийн асуудлуудад анхаардаг болох нь судалгаанаас харагдаж байна.

Бичил санхүү гэж юу вэ?

Бичил зээлийг ядуу буюу орлого багатай иргэдэд санхүүгийн үйлчилгээ үзүүлж чаддаг орон нутгийн байгууллагын тулхтай хөгжлийг хангах зорилгоор олгож эхэлсэн байдаг. Ядуу буюу орлого багатай иргэдэд бусдын адил хөрөнгөтэй болох, амьжиргааны тогтвортой эх үүсвэртэй байх, болзошгүй эрсдлээс орон гэрээ хамгаалахын тулд санхүүгийн олон төрлийн үйлчилгээ хэрэгцээтэй байдаг. Иймээс тэдэнд чиглэсэн бичил санхүүгийн олон төрөлт үйлчилгээ, бүтээгдэхүүнийг бий болгох өгөөжтэй ба найдвартай арга замыг олох нь бичил санхүүгийн байгууллагуудын гол зорилт юм.

Бичил санхүүгийн үйлчлүүлэгч гэж хэн бэ?

Бичил санхүүгийн үйлчлүүлэгчид нь албан ёсны санхүүгийн байгууллагын үйлчилгээг авч чаддаггүй, орлого багатай иргэд юм. Эдгээр иргэд нь ихэнхдээ хувиараа хөдөлмөр эрхэлдэг хүмүүс. Хөдөө

орон нутагт цөөн тооны малтай малчид, бага хэмжээний орлого олдог, түргэн үйлчилгээний цэг, дэлгүүр, цайны газар гэх мэт жижиг бизнес эрхэлдэг хүмүүс хамрагдана. Хот суурин газар бичил санхүүгийн үйлчилгээ илүү олон давхрагын хүмүүст үйлчилдэг ба эдгээр жижиг дэлгүүр, үйлчилгээний газар ажиллуулдаг, гар урлаачид, гудамжны ширхэгийн худалдаачид, гутал тослогчид гэх мэтийн хүмүүсийг хамруулдаг. Бичил санхүүгийн үйлчилгээг харьцангуй тогтвортой орлоготой, ядуу бөгөөд орлого багатай иргэд авдаг. Аливаа санхүүгийн байгууллагын үйлчилгээ нь тухайн хүний орлоготой нягт холбоотой. Хэдий ядуу байна төдий чинээ энэ үйлчилгээ олдохгүй, үнэ өндөр хүнд суртал ихтэй байдаг. Ийм байдлаар санхүүгийн хэрэгцээгээ шийдэж чадахгүй байгаа иргэд бичил санхүүгийн үйлчлүүлэгчид болдог.

Бичил санхүү ядуу буюу орлого багатай иргэдэд хэрхэн тусалж байна вэ?

Бичил санхүү нь орлого нэмэгдүүлэх, санхүүгийн өгөөжтэй бизнес бий болгох, гадны хүчин зүйлээс хамаарах хамаарлыг багасгахад ядуу иргэдэд тусалдаг гэдгийг гадны туршлауд харуулсаар байна. Мөн ядуу буюу орлого багатай иргэд, ялангуяа эмэгтэйчүүдэд, ажлын байртай болж амьдралдаа өөрчлөлт хийх боломжийг олгож чаддаг хүчтэй зэвсэг юм. Ядуурал гэдэг нь олон талтай санхүүгийн үйлчилгээг ядуу буюу орлого багатай иргэдэд хүрснээр бичил санхүү ядуурлыг бууруулахад чиглэсэн үйл ажиллагаанд чухал үүрэг гүйцэтгэнэ. Тухайлбал, бизнесийн өгөөжийг сайжруулах орлогыг нэмэгдүүлэх нь зөвхөн бизнесийн үйл ажиллагааг өргөжүүлэхэд туслаад зогсохгүй мөн өрхийн орлогыг нэмэгдүүлж, хүнсний аюулгүй байдал, хүүхдийн боловсрол зэрэгт сайнаар нөлөөлнө.

Бичил санхүүгийн үйлчилгээ үзүүлдэг байгууллага гэж юу вэ?

Маш энгийнээр бичил санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч байгууллага гэдэг нь ядуу болон орлого багатай иргэдэд санхүүгийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагыг хэлнэ. Бичил санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч олон төрлийн байгууллага бий. Үүнд:

- Төрийн бус байгууллага
- Хадгаламж, зээлийн хоршоо
- Хоршоо
- Жижиг арилжааны банк

- Банк бус санхүүгийн байгууллага хамрагддаг.

Ихэнх бичил санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд нь хүн амын орлого багатай иргэдийг дэмжих зорилготой төрийн бус байгууллагууд байдаг. Эдгээрийн ихэнх нь зээлийг бүлгийн зарчмаар олгож маш бага хэмжээний хадгаламж хуримтлуулах бодлогыг баримталдаг. Үүнээс гадна олон улсын түвшинд санхүүгийн салбарыг өөрчилж, гүнзгийрэхэд чухал үүрэг гүйцэтгэж чадах бас нэгэн бичил санхүүгийн үйлчилгээ үзүүлдэг байгууллага нь хадгаламж, зээлийн хоршоод юм. Тэдгээр нь орон нутагтаа байрлаж өргөн олон гишүүдийг хамарсан байдаг.

Бичил бизнес гэж юу вэ?

- Хувиараа бизнес эрхлэгч эсвэл 10-аас бага тооны ажиллагсадтай
- 5.0 мянган ам.доллараас бага хэмжээний хөрөнгө, эсвэл зээл шаардагдах
- Нийт хөрөнгийн хэмжээ 30.0 мянган ам.доллараас хэтрэхгүй.
- Гэр бүлийн гишүүдийн оролцоотойгоор, ихэнхдээ эзэмшигч нь өөрөө хариуцан явуулдаг бизнесийн үйл ажиллагааг хэлдэг.

Бичил бизнес эрхлэгчид

Дээрх шалгуурт багтаж байгаа аж ахуйн нэгж байгууллагууд

- Үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулж байгаа хувийн болон гэр бүлийн бизнес эрхлэгч иргэд
- Хувийн аж ахуй эрхэлж байгаа тариаланчид, малчид ордог.

Бичил санхүүгийн төрлүүд

- Хадгаламж
- Зээл
- Төлбөр тооцоо
- Мөнгөн гуйвуулга
- Даатгал

- Санхүүгийн түрээс зэрэг багтдаг байна.

Манай оронд үйл ажиллагаа явуулж байгаа бичил санхүүгийн байгууллага бичил бизнес эрхлэгчдэд үйлчилгээ үзүүлэхээс гадна мөн орлого багатай иргэд, төрийн болон хувийн хэвшлийн ажилчид, тэтгэврийн болон ажилгүй иргэд, оюутан залууст үйлчилгээ үзүүлж байна.

Бичил санхүүгийн харилцагчдыг онцлогоор нь:

- **Бизнесийн харилцагчид:** Бизнесийн үйл ажиллагаа явуулдаг, үйл ажиллагаагаа өргөжүүлэн илүү ашиг орлого олохыг эрмэлздэг хуулийн этгээдүүд
- **Бусад харилцагчид:** Ихэвчлэн хувийн хэрэглээ, ахуйн байдлаа дээшлүүлэхийг хүсдэг, ажил эрхлэгч, албан хаагчид, суралцагчид, тэтгэврийн иргэд байдаг.

Бичил санхүүгийн хөгжлийн хандлага

Сүүлийн жилүүдэд дэлхийн улс орнуудын хэмжээнд бичил санхүүгийн зах зээл хурдацтай хөгжиж байна. Судалгаагаар бичил зээлээр амьдралын түвшингээ дээшлүүлсэн ядуу иргэдийн тоо 1997 онд 7.6 сая хүн байсан бол 2005 онд 33.8 сая хүрч өссөн мэдээ байна. Манай улс Мянганы Хөгжлийн Зорилтод хүн амын ядуурлыг 2015 онд 1990 онтой харьцуулахад хоёр дахин бууруулах зорилтыг биелүүлэх үндсэн арга хэрэгсэл нь бичил санхүүгийн үйлчилгээ, ялангуяа бичил зээлийн үйлчилгээ болохыг тодорхойлсон байдаг.

4.2 Ногоон бичил санхүүжилт гэж юу вэ?

“Ногоон бичил санхүү” нь эдийн засаг, нийгэм, байгаль орчны зорилтуудыг хангахын тулд бага орлоготой хүмүүст зээл олгох болон техникийн тусламж, дэмжлэг үзүүлэх зэргээр тогтвортой хөгжлийн зорилтуудыг хангах хамгийн үр нөлөөтэй хэрэгсэл юм. Байгаль орчны өөрчлөлт, доройтолд нийгмийн хамгийн эмзэг бүлэг ихээр өртөх магадлалтай байдаг тул тэднийг хамгаалахад бичил санхүүгийн байгууллагын үүрэг роль чухал байдаг.

Ногоон бичил санхүүг хөгжүүлэх, байгаль орчин, нийгмийн эрсдэлийн удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх, ногоон санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээг хөгжүүлэхэд санхүүгийн байгууллагын удирдлагын

ойлголт, дэмжлэг маш чухал юм. Ногоон бичил санхүүжилт гэдэг нь ердийн банк, санхүүгийн байгууллагаас санхүүгийн үйлчилгээ авч чадахгүй байгаа хувиараа бизнес эрхлэгч, бичил болон ЖДААН-д эдийн засгийн боломж олгох замаар байгаль орчны нөхцөл байдлыг сайжруулах зорилготой санхүүгийн үйлчилгээ юм. Энэ нь бичил санхүүжилт хэрэглэгчдийг илүү тогтвортой, байгаль орчныг хамгаалах, бохирдлыг бууруулах, нөхөн сэргээх, нөөцийг хэмнэх гэх мэт байгаль орчинд ээлтэй байдлаар үйл ажиллагаа явуулахыг дэмжиж байдаг. Үүний зэрэгцээ хөрөнгө оруулагчид ашигтай хөрөнгө оруулалт, төслүүд болон түүнийг санхүүжүүлэх бүтээгдэхүүн, санхүүгийн хэрэгслийг багтаадаг (Gonzalez, 2016).

Ногоон бичил санхүүжилт нь сүүлийн үеийн шинэ судалгааны салбар бөгөөд бичил санхүү болон уур амьсгалын өөрчлөлт хэмээх 2 ойлголтын нийлбэрээс үүсэн бий болсон. Олон жилийн турш уур амьсгалын өөрчлөлт нь бичил санхүүгийн салбарын хувьд хамаагүй юм шиг явсаар ирсэн ба сүүлийн 10 жилийн хугацаанд уур амьсгалын өөрчлөлтийг бичил санхүүгийн салбараар дамжуулан хэрэгжүүлэх нь үлэмж ач холбогдолтой болох нь батлагдсаар байна.

Сүүлийн хэдэн арван жилийн хугацаанд бичил санхүү олон улсын түвшинд эрч хүчээ авч, орон нутгийн ядуу, бага дунд орлоготой иргэдийн бүлэгтэй нягт уялдаатай санхүүгийн зах зээл болж, нийгмийн чадавхийг бий болгохын тулд тэд ажиллаж байна. Ядуурлыг дэмжих чиглэлийн санхүүгийн үйл ажиллагаа үргэлжлэхийн хэрээр дэлхийн дулаарал ба үүнтэй холбоотой дэлхийн уур амьсгалын хэв маяг өөрчлөгдөж байгаа нь бичил санхүүгийн эрхэм зорилгын шинэ эрсдлийн эх үүсвэр болж байна.

Газарзүйн байрлалаас шалтгаалан ихэнх хөгжиж буй орнууд болон тэдний хүн ам цаг уурын эрс тэс тохиолдлуудтай тэмцэж байна. Аадар бороо, шуурга, хүчтэй ган гачиг, мөн температур нэмэгдэхийн хэрээр ийм үзэгдлүүд улам их гарч, дэлхийн хамгийн ядуу хүн амд нэмэлт ачаа үүрүүлж байна. Дэлхийн цаг уурын эрсдлийн индекс 2015-аас харахад “1994-2013 онуудад цаг агаартай холбоотой хамгийн их нөлөөлөлд өртсөн 10 орны ес нь бага орлоготой буюу дунд орлоготой хөгжиж буй орнууд байсан” (Kreft, Eckstein, Junghans, Kerestan, & Hagen, 2014). Үүнтэй адил хур тунадасны хэлбэлзэл мэдэгдэхүйц нэмэгдэх нь ихэнх хөгжиж буй орнуудын ДНБ-ийг бууруулж, ядуурлыг нэмэгдүүлэх болно гэж Дэлхийн банк үзэж байна (World Bank, 2010).

Ногоон бичил санхүүжилт яагаад чухал вэ?

Бичил санхүүгийн хамгийн том давуу тал нь санхүүгийн үйлчилгээний

хүртээмжтэй байдлыг нийгмийн бүхий л давхаргынханд хүргэх байдаг учраас бичил санхүүгийн салбарт байгаль орчинд ээлтэй байх шаардлагыг тавьснаар тогтвортой хөгжлийн зорилтод хүрэхэд чухал нөлөө үзүүлнэ.

4.3 Тогтвортой бичил санхүүгийн зарчмууд

Зарчим 1 – Бичил санхүүгийн үйлчилгээ нь үйлчлүүлэгчдийнхээ хэрэгцээ шаардлагад нийцсэн байх ёстой.

Зарчим 2 – Ядуу өрх болон нийгмийн бүлэг нь зээлээс гадна бусад олон төрлийн санхүүгийн үйлчилгээ ашиглах хэрэгцээтэй байдаг.

Зарчим 3 – Бичил санхүү нь ядуурлыг бууруулах хүчирхэг хэрэгсэл юм.

Зарчим 4 – Бичил санхүү гэдэг нь нийгмийн доод бүлэгт үйлчлэх санхүүгийн системийг бий болгохыг хэлнэ.

Зарчим 5 – Санхүүгийн тогтвортой байдал нь тодорхой тооны ядуу буурай иргэдэд хүрч үйлчлэх, хүртээмжтэй байдлыг шаарддаг.

Зарчим 6 – Хүүний түвшний дээд хязгаар нь ядуу буурай иргэдийн санхүүгийн үйлчилгээ авахад таагүй байдлыг үүсгэдэг.

Зарчим 7 – Зээлийн үйлчилгээ нь хүн бүрт тохиромжтой байдаггүй.

Зарчим 8 – Засгийн газрын үүрэг нь аливаа зүйлийг боломжтой байлгах явдал юм, харин санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч биш юм.

Зарчим 9 – Хандивлагчдаас өгсөн мөнгөн тусламж нь нэмэгдэл юм.

Зарчим 10 – Байгууллагын болон хүний нөөц бололцоо дутуу байгаа нь бичил санхүүгийн тэлэлтийг хязгаарлах гол хүчин зүйл юм.

Зарчим 11 - Санхүүгийн болон мэдээллийн ил тод байдал чухал ач холбогдолтой (Australia, 2006) (CGap, 2004).

Дэлхийн олон улс орнуудад тогтвортой бичил санхүүгийн зарчмуудыг дээрх 11 хүчин зүйлсээр тодорхойлж, бичил санхүүгийн байгууллагууд нь бичил бизнес эрхлэгчид болон бага, дунд орлоготой иргэдийг дэмжих замаар тогтвортой хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.

Шигтгээ: 2

**Монгол улсын санхүүгийн хүртээмжийн
индикатор (IFC, 2014)**

| № | Бүлэг | Индикатор | 2010 | 2011 | 2012 | 2013 | 2014 |
|---|--|---|--------|--------|----------|----------|----------|
| 1 | Газарзүйн байршлаар | 1000 км ² тутам дахь арилжааны банкны салбарын тоо | 0,70 | 0,85 | 0,90 | 0,94 | 0,97 |
| | | 1000 км ² тутам дахь АТМ-н тоо | 0,24 | 0,41 | 0,59 | 0,66 | 0,79 |
| | | 100 000 хүн тутам дахь АТМ-н тоо | 18,52 | 31,51 | 44,85 | 49,98 | 58,78 |
| 2 | Санхүүгийн үйлчилгээг ашиглаж буй байдлаар | 1000 хүн тутам дахь арилжааны банкин дахь хадгаламжийн данс | 847,07 | 935,32 | 1 052,17 | 1 207,58 | 1 297,63 |
| | | 1000 хүн тутам дахь арилжааны банкин дахь зээлийн данс | 263,94 | 301,30 | 301,26 | 336,09 | 384,06 |
| 3 | Дансны хэмжээ | Арилжааны банкны хадгаламжийн хэмжээ | 43,37 | 43,81 | 38,71 | 39,48 | 39,14 |
| | | Арилжааны банкны зээлийн хэмжээ | 31,87 | 41,39 | 41,59 | 56,05 | 56,95 |
| | | Арилжааны банкин дахь ЖДБЭ-н зээлийн хэмжээ | 2,85 | 3,60 | 3,54 | 5,08 | 5,82 |
| | | Арилжааны банкин дахь өрх гэрийн зээлийн хэмжээ | 13,67 | 18,52 | 18,42 | 24,27 | 25,86 |

Шигтгээ: 3

Санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, ядуу иргэдэд санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг хүртээмжтэй болгох талаар авч хэрэгжүүлсэн олон улсын кейс туршлага

| Улс орон | Хэрэгжүүлсэн хугацаа, байгууллага | Авсан арга хэмжээ | Хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр | Үр дүн |
|----------|--|--|---|---|
| Шри Ланк | Үндэсний хөгжлийн итгэлийн сан /ҮХИС/, 1991 он | ТББ, банкуудыг дамжин зээлдүүлэгч болгон ядууст барьцаа хөрөнгөгүй зээл авах боломж олгодог. | Энэ байгууллагын гол үйл ажиллагаа нь ядуурлыг бууруулах зорилгоор нийгмийн ядуу хэсгийнхэнд бичил зээлийг хүргэх хөтөлбөр хэрэгжүүлэх явдал юм | 1990 онд хадгаламж болон зээлийн хэмжээ тус тус 491, 448 сая байсан бол 2003 онд буюу 13 жилийн дотор маш хурдацтай өсөж хадгаламжийн хэмжээ 4205 сая болон зээлийн хэмжээ 2844 сая болсон байна. |
| Япон | Японы санхүүгийн корпораци (JFC), 2003 он | Батлан даагчгүй эсвэл барьцаагүй зээл авахыг хүсдэг бичил болон жижиг байгууллагуудын хэрэгцээнд нийцсэн зээл олгож эхэлсэн. | JFC-Micro зээлийн хөтөлбөр, Банк болон бусад санхүүгийн байгууллагууд өгдөггүй бичил зээлийг JFC микро санхүүгийн байгууллага нь олгодог | Барьцаа хөрөнгөгүй зээлдэгчид 80% буюу хамгийн их хувийг эзлэхээс гадна 3-5 жилийн буюу дунд хугацааны зээлүүд 72%-ийг эзэлж байна. Нийтэд нь дүгнэхэд бичил хэмжээний бага хугацаатай барьцаа хөрөнгө болон бага хөрөнгө оруулалттай зээлдэгчид ихэнх хувийг эзлэх болсон. |



| | | | | |
|---------|--|--|---|--|
| Энэтхэг | | <p>Ядуу иргэдийг зохион байгуулж, ихэвчлэн 15-20 эмэгтэйг нэг бүлгэм болгон тэднийг хуримтлалтай болох байнгын зуршлыг бий болгоход нь тусалдаг.</p> | <p>Өөртөө туслах бүлгэм – Банкуудыг жирийн иргэдтэй холбох хөтөлбөр</p> | <p>Хөрөнгийн хэмжээ дундажаар 72% өссөн ба 1 гишүүнд ногдох дундаж хадгаламж гурав дахин нэмэгдсэн. Өрх гэр тус бүрт ногдох дундаж зээл Rs4,282-оос Rs8,341 болон өссөн, ажил эрхлэлт дундажаар жилийн 318 өдрөөс 375 өдөр болж, тариалангийн бус үйл ажиллагаанаас үүссэн ажил эрхлэлтийн хэмжээ өссөн,</p> |
|---------|--|--|---|--|

| | | | | |
|------|---|--|---|--|
| Лаос | Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн (GIZ) захиалгаар Австралийн тусламжийн байгууллага (Australia Aid), MMG уул уурхайн компани хамтран санхүүжүүлснээр төсөл, 2009 он | Төслийн хүрээнд санхүүгийн хүртээмж ба эмэгтэйчүүдийн санхүүгийн оролцоо, хөдөө орон нутгийн иргэдийн санхүүгийн боловсрол, хөдөө орон нутгийн санхүүгийн эрэлт, эмэгтэйчүүдийн санхүүгийн хүртээмж гэх санал асуулгыг иргэдээс авчээ. | Лаос улсад хэрэгжиж буй “Хөдөө орон нутаг дах бичил санхүү – Ядуу иргэдийн санхүүгийн хүртээмж” төсөл | 2014 оны 11 сар гэхэд 37,000 данс бүхий 430 тосгоны банкны суурийг тавьсан. Эдгээр дансуудын дийлэнх нь өрх гэрийн данс байх ба хувийн данс эзэмшигчдийн 55%-ийг эмэгтэйчүүд эзэлж байна. Төслийн үр дүнд шийдвэр гаргах байр сууринд байх эмэгтэйчүүдийн тоо 28%-аар нэмэгджээ. Нийт хуримтлуулсан хадгаламжийн хэмжээ одоогын байдлаар 31 тэр бум кип (3.1 сая евро) даваад байгаа бөгөөд хуримтлуулсан хадгаламжийн өсөлт 73.6 хувьтай байна. |
|------|---|--|---|--|

Бичил бизнес эрхлэгчдэд хүрэх санхүүгийн хүртээмж үйлчилгээг сайжруулснаар зөвхөн улсын эдийн засагт төдийгүй санхүүгийн байгууллагуудад /зээлдүүлэгчдэд/ ч ашигтай. Санхүүгийн салбар сайжирснаар дараах үр дүнд хүрнэ.

- Эдийн засгийн өсөлтөд дэмжлэг болно,
- Ажилгүйдэл буурна,
- Орлогын үр ашигтай хуваарилалт нэмэгдэнэ,
- Ядуурлын түвшин багасна.

БИЧИЛ САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ УДИРДЛАГЫН ТОГТОЛЦОО

Энэ сэдвийн хүрээнд дараах зүйлсийн талаар судлах болно. Үүнд:

- Байгаль орчин, нийгмийн удирдлагын тогтолцоо, түүний зорилго, хэрэгцээ шаардлага
- БОНУТ гэж юу вэ?
- БОНУТ-ийг хэрэгжүүлэх үе шат
- БОНУТ-ний зорилго, ач холбогдол
- БОНУТ-ын бүрэлдэхүүн хэсэг
- БОН-ийн эрсдэл, эрсдэлийн үнэлгээний процесс
- БОНУТ-ний тайлагнал

2.1 БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГМИЙН УДИРДЛАГЫН, ТҮҮНИЙ ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА

Удирдлагын тогтолцоо

Байгаль орчин, нийгмийн удирдлагын тогтолцоог тайлбарлахын тулд удирдлагын тогтолцоо гэсэн ойлголтыг эхлээд тайлбарлая. Удирдлагын тогтолцоо (систем) гэдэг нь аливаа байгууллага тавьсан зорилгодоо хүрэхийн тулд боловсруулсан бодлого, бизнесийн дүрэм, түүнд нийцүүлэн өдөр тутмын үйл ажиллагаандаа дагаж мөрдөх журам, процесс, удирдлагын арга барил юм. Энэхүү зорилго нь байгууллагын санхүү, аюулгүй ажиллагаа, бүтээгдэхүүний чанар, үйлчлүүлэгчийн харилцаа, хууль эрх зүйн зохицуулалт, байгаль орчины зэрэг бүхий л зүйлүүдийг хамардаг. Удирдлагын тогтолцооны нарийн төвөгтэй байдал нь байгууллага бүрийн хувьд харилцан адилгүй нөхцөл байдлаас хамаарна. Энэ нь зөвхөн дүрэм журам бодлогоор

хязгаарлагдахгүй, хэрхэн хэрэгжүүлэх, сайжруулах тухай ойлголт юм. ISO удирдлагын тогтолцооны стандартууд нь байгууллагад дээрх зорилгодоо хүрэхэд нь тусладаг. Тухайлбал:



- ISO9000 Чанарын удирдлагын тогтолцоо
- ISO14000 Байгаль орчны удирдлагын тогтолцоо
- ISO45001 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн удирдлагын тогтолцоо
- ISO27000 Мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо
- ISO26000 Нийгмийн хариуцлагын удирдлагын систем
- ISO31000 Эрсдэлийн удирдлагын тогтолцоо гэх мэт.....

Тэгвэл байгаль орчин, нийгмийн удирдлагын тогтолцоо гэж юу вэ? яагаад хэрэгжүүлэх хэрэгтэй хэрэгтэй вэ? гэсэн асуултууд гарч ирэх юм. Эдгээр асуултанд хариулахын тулд байгаль орчин, нийгмийн хүчин зүйлийн нөлөөлөл, үүсэж болох эрсдэлүүдийн талаар судлах нь зайлшгүй юм.

Байгаль орчны өөрчлөлт, түүний нөлөө

Аж үйлдвэрийн өсөлт, хүлэмжийн хийнээс улбаалан дэлхийн дулаарал, цэвэр усны нөөцийн хомдол, хөрсний бохирдол, байгалийн нөөцийн хомсдол, хэт их хэрэглээ, замбараагүй хог хаягдал зэрэг хүн төрөлхтний өмнө тулгамдсан эдгээр асуудлууд нь дэлхийн улс

орнуудыг тогтвортой эдийн засаг, ногоон эдийн засаг руу шилжих хэрэгцээ шаардлага байгааг харуулсаар байна. Учир нь экосистемийн доройтол, дэлхийн дулаарал, уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалан дараагийн зуун жилд амьтан ургамал 20-30 хувь устгах, ундны усны хомсдолоос шалгаалж хэдэн тэрбум хүн эрүүл мэнд амь насаараа хохирох талаар сүүлийн жилүүдэд яригдаж байна. Ялангуяа ядуу буурай, хөгжиж буй улс орнууд уур амьсгалын өөрчлөлтөөс хамгийн их хохирол амсаж болзошгүй гэж судлаачид үзэж байна.

Дэлхийн уур амьсгалын өөрчлөлт, экосистемийн доройтол Монгол улсыг ч тойрон гарахгүй гэдгийг та бид мэдэж байгаа билээ. Тухайлбал, Монгол орны жилийн дундаж агаарын температур ойролцоогоор сүүлийн 80 жилд 2.25°C-ээр дулаарсан байна. Мөн 1990 оноос хойш агаарын дундаж температурын өсөлт эрчимжсээр хамгийн дулаан жил 2007 онд тэмдэглэгдсэн байна. Харин 2019 оны агаарын дундаж температур 1.2°C байсан нь 1940 оноос хойш ажиглагдсан 5 дахь дулаан жил байсан ба энэхүү дулаарал, хэт хуурайшилтаас шалтгаалан олон тооны гол горхи ширгэж үгүй болсон байна. Мөн түүнчлэн мал аж ахуй, газар тариалан, ойн аж ахуйн салбарт үзүүлэх сөрөг нөлөөлөл нэмэгдэж, бэлчээрийн зохисгүй ашиглалт, уул уурхайн үйл ажиллагаа, уур амьсгалын дулаарал зэргээс үүдэлтэй хөрсний доройтол, цөлжилт эрчимтэй явагдаж байна. НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх конвенцийн (United Nations Convention to Combat Desertification, цаашид “UNCCD”) тодорхойлолтыг үндэслэн тооцвол Монгол улсын бараг 90% нь хөрсний доройтол, цөлжилтөд өртөмтгий газрын ангилалд орсон байна. 2015 оны судалгаанаас харахад Монгол улсын нутаг дэвсгэрийн 76.8% хөрсний доройтол, цөлжилтөнд өртсөн байна (БОАЖЯ, 2017).

Уур амьсгалын өөрчлөлт (Climate change) нь байгалийн болон бусад хүчин зүйлийн нөлөө, түүний дотор хүний үйл ажиллагаанаас ихээхэн шалтгаалж байна. Тиймээс ч хөгжиж буй улс орнуудын эдийн засаг өсөн нэмэгдэхийн хэрээр байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөө нэмэгдэх хандлагатай байдаг. Хөгжиж буй улс орнуудын хувьд эдгээр хүнд үйлдвэр, уул уурхайд суурилсан эдийн засгийн бүтэцтэй байдаг тул байгаль орчны бохирдлын асуудал хурцаар тавигддаг. Уул уурхай, эрчим хүчний салбар нь байгаль орчинг хамгийн ихээр бохирдуулдаг салбаруудыг тэргүүлдэг байна. Тус салбарын эрэлтийг эрчим хүч, аж үйлдвэрийн салбарууд их хэмжээгээр бий болгодог байна. АНУ-н IEA байгууллагаас гаргасан таамаглалаар 2040 он гэхэд эрчим хүчний хэрэглээ өнөөгийн түвшингээс даруй 1.5 дахин нэмэгдэх хандлагатай гэж үзсэн. Энэ нь уул уурхайн салбарын өсөлтийг бий болгох хэдий ч харин энэхүү өсөлтийг хэрхэн байгаль орчинд бага сөрөг нөлөөлөлтэй бий болгох вэ? гэдэг нь дэлхий нийтийн санаа зовинох асуудал болоод




байна. Монгол улсын хувьд уул уурхайн салбарын нөлөөгөөр эдийн засаг хурдацтай өссөөр байгаа хэдий ч байгаль орчин нийгэмд үзүүлэх уул уурхайн салбарын сөрөг нөлөөлөл их байгаа нь ард иргэдийн эсэргүүцэлтэй тулгарахад хүргэсээр байна. Жишээлбэл, 2015 онд НҮБ-ийн Хөгжлийн хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр хэрэгжүүлсэн “Монгол улсын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тогтолцоог бэхжүүлэх” төслийн хүрээнд Өмнөговь аймгийн Ханбогд сумын эдийн засаг, нийгэм, байгаль орчинд уул салбарын нөлөөллийн судалгаа хийсэн байдаг. Уг судалгааны үр дүнгээс уул уурхайн салбарын байгаль орчинд үзүүлж буй сөрөг нөлөөлөл их болох нь харагдаж байна. Судалгаанаас харахад оролцогчдын 70% нь уул уурхайн салбарын байгаль орчинд эерэг нөлөө байхгүй гэж хариулсан байна.

Зураг 10. Уул уурхайн салбарын байгаль орчинд үзүүлсэн сөрөг нөлөөлөл, дүнд эзлэх хувь



Эх сурвалж: Өмнөговь аймгийн Ханбогд сумын эдийн засаг, нийгэм, байгаль орчинд уул салбарын нөлөөллийн судалгаа, 2015


Зураг 11. Уул уурхайн салбарын нийгэмд үзүүлсэн сөрөг нөлөөлөл, дүнд эзлэх хувь



Эх сурвалж: Өмнөговь аймгийн Ханбогд сумын эдийн засаг, нийгэм, байгаль орчинд уул салбарын нөлөөллийн судалгаа, 2015

Зураг 12. Уул уурхайн салбарын байгаль орчинд үзүүлсэн эерэг нөлөөлөл, дүнд

ээлэх хувь



Эх сурвалж: Өмнөговь аймгийн Ханбогд сумын эдийн засаг, нийгэм, байгаль орчинд уул салбарын нөлөөллийн судалгаа, 2015

Цаашид ч дэлхийн уур амьсгалын урт хугацааны өөрчлөлт нь агаарын хэмийг нэмэгдүүлээд зогсохгүй үер ус, цөлжилт зэрэг байгалийн гаралтай аюулт үзэгдэлийн эрсдэлийг нэмэгдүүлнэ. Монгол улсын хувьд уур амьсгалын өөрчлөлтөд илүү өртөмтгий салбарууд нь газар тариалан, мал аж ахуй, газар ашиглалт, усны нөөц, эрчим хүч, аялал жуулчлал, орон сууц нийтийн аж ахуйн салбар юм. Тиймээс компаниуд хүн төрөлхтөн, байгаль орчин, нийгэмдээ ээлтэй, хариуцлагатай үйл ажиллагаа явуулах, олон улсын болон дотоодын хууль тогтоомж, байгаль орчны шинэ зохицуулалт, шаардлагуудыг дагаж мөрдөх шаардлагууд улам бүр нэмэгдэж байна. Байгаль орчин нийгмийн асуудал нь байгууллагын нэр хүнд, ашиг орлого, эрсдэлтэй шууд хамааралтай болж байна.


Байгаль орчин, нийгмийн удирдлагын тогтолцоо нь хамгийн энгийн авч үзвэл байгаль орчин, нийгмийн хүчин зүйлтэй холбоотой эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, удирдахад чиглэгдсэн удирдлагын тогтолцоо юм. БОНУТ-г хэрэгжүүлсэнээр компаниуд байгаль орчин, нийгмийн асуудалтай холбоотой бизнесийн эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх, хамгаалах улмаар зах зээлээ тэлэх, бүтээгдэхүүн үйлчилгээг хөгжүүлэх, бизнесийн нэр хүндээ нэмэгдүүлэх, хямд зардалтай эх үүсвэр татах зэрэг ач холбогдолтой.

2.2 БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГМИЙН УДИРДЛАГЫН ТОГТОЛЦОО

Байгаль орчин, нийгмийн эрсдэлийн удирдлагын тогтолцоо (цаашид БОНУТ гэх) гэдэг нь байгаль орчин, нийгмийн асуудлуудад чиглэсэн компанийн амлалт буюу бодлого, байгаль орчин, нийгмийн эрсдэлийг шийдвэр гаргалтанд хэрхэн тусгах, таньж мэдэх, удирдах, арилгах процессыг дэлгэрэнгүй тусгасан журам, мэргэшсэн ажилтнуудад, шаардагдах ур чадвар, дотоод нөөц, үүрэг хариуцлагын тогтолцоог бүрдүүлэх замаар байгаль орчин, нийгмийн асуудлыг өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэгжүүлж, удирдах цогц тогтолцоог хэлнэ.

Санхүүгийн үйлчилгээний салбар нь хөдөө аж ахуй, уул уурхай, эрчим хүчний салбартай харьцуулахад байгаль орчин, нийгэмд үзүүлэх сөрөг нөлөө багатай салбар гэдгийг олон судалгаанаас харж болно. Гэхдээ банк, санхүүгийн байгууллагын хувьд яагаад байгаль орчин, нийгмийн хүчин зүйлийн нөлөөллийг анхаарч үзэх шаардлагатай вэ? гэсэн асуулт гарч ирж болох юм. Санхүүгийн байгууллага нь харилцагчийн үйл ажиллагааг сайтар ойлгоогүй, байгаль орчин, нийгмийн хүчин зүйлээс үүсэх эрсдэлийг анхаараагүйгээс үүдэж санхүүгийн байгууллагын үйл ажиллагаанд дор дурдсан эрсдэлүүд үүсэж болох юм.

Зураг 13. Байгаль орчин, нийгмийн санхүүгийн байгууллагад үзүүлэх нөлөө



Эх сурвалж: EBRD.

Тиймээс тогтвортой хөгжлийн тогтолцооны суурийг бэхжүүлэх, хэрэгжилтийг хурдасгахад санхүүгийн хөшүүрэг чухал нөлөөтэй учир банк, санхүүгийн байгууллагууд **тогтвортой санхүүжилтийн үзэл баримтлалаар** дамжуулан улс орныхоо тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулах боломжтой байдаг.

Тогтвортой, ногоон санхүү (Sustainable, green finance) гэдэг ойлголтыг байгаль орчинд ээлтэй төслүүдийг санхүүжүүлэх явдал гэж энгийнээр ойлгож болох юм. Ногоон санхүү нь санхүүгийн системийн хүрээнд байгаль орчины эрсдэлийг үр дүнтэй удирдахыг шаарддаг. Тиймээс ногоон санхүү нь дараах 2 гол ойлголтыг өөртөө багтаадаг. Үүнд:

1. Байгаль орчин, нийгмийн эрсдэлийн удирдлагыг бизнесийн шийдвэр гаргалтад ашиглах;
2. Ногоон хөрөнгө оруулалт болон ногоон санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх.

Учир нь санхүүгийн байгууллага нь байгаль орчин, нийгмийн эрсдэл болон боломжуудыг үр дүнтэй удирдсанаар урт хугацааны бизнесийн үнэ цэнийг бий болгох, өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэх боломжтой юм. Өөрөөр хэлбэл санхүүгийн байгууллага нь ямар нэг төслийг санхүүжүүлэх гэж байгаа бол тухайн төсөл байгаль орчинд ямар нэг сөрөг нөлөө үзүүлэх эсэхийг зээл олгохоос өмнө судлах, болзошгүй эрсдэлийг бууруулах арга хэмжээ авах, өөрийн харилцагчийг эрсдэлээс хамгаалах, улмаар өөрийн олгосон зээлээ эрсдэлд орохоос сэргийлж, санхүүгийн байгууллага өөрийн үйл ажиллагааг ч эрсдэлээс хамгаалж байгаа юм. Мөн түүнчлэн байгаль орчинд ээлтэй ногоон төслүүдийн санхүүжүүлтийг нэмэгдүүлж, ногоон хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлсэнээр санхүүгийн байгууллагын хувьд зах зээлээ тэлэх, шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлэх боломжууд бий болох юм.

Тиймээс санхүүгийн байгууллагын хувьд БОНУТ нь аливаа санхүүгийн байгууллага өөрийн, харилцагч талуудын үйл ажиллагаанаас учирч болох байгаль орчин, нийгмийн хүчин зүйлтэй холбоотой эрсдэлийг тодорхойлох, удирдах, бууруулахад чиглэсэн дотоод бодлого, журам, хэрэгжүүлэх үйл явц, тэдгээрийг тайлагнахтай холбоотой зохицуулсан тогтолцоо, систем юм (С.Дашдорж, 2019).

ОУСК-ийн хувьд санхүүгийн байгууллагын БОНУТ нь байгаль орчин, нийгмийн эрсдэлийн удирдлагыг санхүүгийн байгууллагын бизнесийн үйл явцтай нэгтгэсэн тогтолцоо гэж тодорхойлсон байдаг.

Тиймээс санхүүгийн байгууллагын БОНУТ нь санхүүгийн байгууллагын одоогийн эрсдэлийн удирдлагын процедуртай хамтад нь хэрэгжүүлэх бодлого, үйл явц, процедурын бүрдэл юм. Энэхүү бодлого, процедурыг дангаар нь эсвэл одоогийн эрсдэлийн удирдлагын бодлого, журамтай нэгтгэсэн байдлаар боловсруулж, баримтжуулан, үйл ажиллагаандаа мөрдлөг болгох хэрэгтэй.


2019 онд ББСБ-уудаас авсан судалгааны үр дүнгээс харахад 85 хувь БОН-ийн талаар баримтлах тусгай бодлого байхгүй, 87 хувь нь БОН-ийн асуудал хариуцсан нэгж, албан тушаалтан байхгүй, 86 хувь БОН-ийн гүйцэтгэлийн талаар ТУЗ болон гүйцэтгэх удирдлагад мэдээлдэггүй харин 90 хувь нь БОН-ийн гүйцэтгэлийн талаар гадаад оролцогч талуудад мэдээлдэггүй, 86 хувь нь БОНЭ-ийг үнэлэх тусгай аргачлал ашигладаггүй, эрсдэлийн түвшингээр ангилдаггүй мөн ажилтнуудаа энэ талаар сургаж, мэдээлэл өгдөггүй гэж гарсан (А.Одгэрэл, 2020). Энэхүү судалгааны үр дүнгээс ББСБ-уудын хувьд БОНУТ бүрдээгүй сул хөгжилтэй байна гэж үзэж болохоор байна.

Харин ОУСК-ийн зүгээс 2014 онд хөгжиж буй 9 улсын 123 санхүүгийн



байгууллагыг хамруулан БОНУТ-г хөгжүүлэх, нэвтрүүлэхэд тулгамдаж буй асуудал, хүчин зүйлсийг судласан ба уг судалгаагаар судалгаанд хамарсан дийлэнх улсуудын хувьд салбарын тусгай заавар журам, эрхзүйн зохицуулалт, удирдлагын дэмжлэг сул байдал нь гол тулгамдаж буй асуудал (Зураг 14) гэж гарсан байна. Харин судалгааны хамрагдсан улсуудын дийлэнх нь БОНУТ-ийг хөгжүүлж, нэвтрүүлэхэд зохицуулагч байгууллагын дүрэм журам хамгийн чухал гэж үзсэн байна.

Зураг 14. БОНУТ-г нэвтрүүлэхэд санхүүгийн байгууллагад тулгамдаж буй асуудал



Эх сурвалж: *Moving forward with ERMS: Findings from IFC Country Baseline Surveys-2014*

БОНУТ-ийг хөгжүүлж, нэвтрүүлэхэд зохицуулагч байгууллагын дүрэм журам хамгийн чухал гэж үзсэн байна.

Одоогийн байдлаар Монгол улсад үйл явуулж буй 14 банк өөрсдийн үйл ажиллагаандаа мөрдөх БОНУТ-г баталж, хөрөнгө оруулалт, санхүүжилтийн үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. Банкуудын хувьд өөрсдийн үйл ажиллагаандаа БОНУТ-г нэвтрүүлсэнээр 50 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй бүх төрлийн бизнесийн зээл олгохоос өмнө зээлдэгчийн байгаль орчин, нийгмийн эрсдэлийг үнэлж, эрсдэлийг бууруулах шаардлагатай арга хэмжээг авч ажиллаж байна. 2020 оны 1 р улиралаас эхлэн “Ногоон таксономи”-ийн ангилалын дагуу Монгол банк арилжааны банкуудын олгосон “Ногоон зээлийн тайлан” гаргаж олон нийтэд мэдээлж байна.

Иймд бичил санхүүгийн байгууллага нь БОНУТ-ийн эрсдэлийн удирдлагын бодлого журам тусад нь боловсруулах эсвэл одоо мөрдөж буй эрсдэлийн удирдлагын бодлого журамд холбогдох өөрчлөлтийг оруулах замаар хэрэгжүүлж болно. Тухайн санхүүгийн байгууллага, компанийн удирдлагын зүгээс байгаль орчны асуудлыг анхаарч, ойлгосноор БОНУТ-г амжилттай хэрэгжүүлэх боломж бүрдэх юм.

2.3 БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГМИЙН УДИРДЛАГЫН ТОГТОЛЦООГ НЭВТРҮҮЛЭХ ҮЕ ШАТ

Компани, байгууллагууд өөрийн үйл ажиллагаандаа БОНУТ-ыг бий болгохын тулд дараах 8 алхамыг хэрэгжүүлнэ.

Үүнд:

1. БОН-ийн зорилт, амлалтыг тодорхойлох
2. БОНУТ-г хөгжүүлж, нэвтрүүлэх ажлын хэсэг байгуулах
3. БОН-ийн эрсдэл, боломж, хуулийн болон бусад шаардлагыг тодорхойлох
4. БОН-н стандарт гаргах
5. БОН-ын удирдлагын бодлого боловсруулах
6. Дүрэм журам боловсруулж, одоогийн эрсдэлийн удирдлагын тогтолцоотой уялдуулах
7. Үүрэг, хариуцлагыг тодорхойлох
8. Хэрэгжүүлэх төлөвлөгөө гаргах

Үүнийг БОНУТ-г хөгжүүлэх алхамуудыг төлөвлөх, нэвтрүүлэх гэсэн 2 үе шатанд ангилж авч үздэг.

Зураг 15. БОНУТ-г хөгжүүлэх үе шат



Эх сурвалж: FIRST for Sustainability, IFC

Санхүүгийн байгууллагуудын хувьд БОНУТ-г амжилттай хөгжүүлж, нэвтрүүлэхэд тухайн санхүүгийн байгууллагын засаглах болон гүйцэтгэх удирдлагын үүрэг оролцоо маш чухал юм. Мөн ОУСК-ийн хийсэн судалгааны тайланд хөгжиж буй улс орнуудын хувьд БОНУТ-ийг хөгжүүлж, нэвтрүүлэхэд эрх бүхий байгууллагын зохицуулалт чухал болохыг дурдсан байна.

2.4 БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГМИЙН УДИРДЛАГЫН ТОГТОЛЦООНЫ ЗОРИЛГО, АЧ ХОЛБОГДОЛ

БОНУТ нь санхүүгийн байгууллагад дараах зорилгоор хэрэгждэг. Үүнд:

1. Санхүүгийн байгууллагын үйл ажиллагаа нь байгаль орчин, нийгмийн удирдлагын стандартуудтай нийцэж байгаа эсэхийг баталгаажуулах.
 - Монголын улсын холбогдох хууль, тогтоох
 - Монголын улсын ТоС-ын зарчмууд
 - Олон улсын конвенц, стандарт, гэрээний шаардлагууд
 - Бусад хөрөнгө оруулагч, хамтран ажиллагч байгууллагын шаардлагууд
2. Өөрийн болон харилцагчийн үйл ажиллагаатай холбоотой байгаль орчин, нийгмийн эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, бууруулах, хянахад туслах;
3. Байгаль орчин, нийгмийн эрсдэлтэй байж болзошгүй зээлээс зайлсхийх болон удирдахад санхүүгийн байгууллагуудад туслах;


БОНУТ-г хэрэгжүүлсэнээр санхүүгийн байгууллагад дараах давуу тал, ач холбогдол бий болно. Үүнд:

- Хөрөнгө оруулалтын багцын эрсдэлээ таних
- Байгаль орчин, нийгмийн эрсдэлийг үнэлэх, бууруулах, хянах нэгдсэн тогтолцоотой болох
- Зээлийн эрсдэл бууруулах
- Зах зээлийн эрсдэл бууруулах

- Шинэ бизнес, зах зээлийн боломж нээх
- Бизнесийн үр ашиг нэмэгдэх
- Бизнесийн нэр хүнд өсөх

ОУСК-ийн судалгааны тайланд дурдсанаар санхүүгийн байгууллагууд БОНУТ-ийг хэрэгжүүлсэнээр зээлийн багцын чанар сайжрах, брэндийн үнэ цэн өсөх, хөрөнгө оруулалт татах, шинэ бизнесийн боломж нэмэгдэх, рэйтэнг өсөх зэрэг өгөөжийг хүртэх боломжтой гэж үзсэн.

Зураг 16. БОНУТ-г нэвтрүүлсэнээр СБ-ийн хүртэх боломжит өгөөж (СБ-ийн %)



Эх сурвалж: Moving forward with ERMS: Findings from IFC Country Baseline Surveys-2014

Санхүүгийн байгууллага БОНУТ-ны сайн бодлого, дүрэм журам боловсруулсан ч хэрэгжүүлэлт нь сул байвал дээрх үр дүн, өгөөжийг хүртэх боломжгүй юм. Иймд санхүүгийн байгууллага БОНУТ-г бий болгоно гэдэг байгаль орчин, нийгмийн эрсдлийн удирдлагын бодлого, дүрэм журмыг боловсруулахаас гадна түүнийг хэрэгжүүлэх хүний нөөцийг бүрдүүлэх, мөрдүүлэх, тасралтгүй сайжруулалт хийх явдал юм.

2.5 БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГМИЙН УДИРДЛАГЫН ТОГТОЛЦООНЫ БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ

Байгууллагын БОНУТ нь өөр хоорондоо уялдаа холбоо, хамаарал бүхий дараах 9 элементээс бүрдэх бөгөөд элемент тус бүр байгаль орчин, нийгмийн эрсдэлийг үнэлж, хянах замаар БОНУТ-г тасралтгүй сайжруулахад чухал ач холбогдолтой. Бүрдэл хэсэг бүр уг тогтолцооны салшгүй хэсэг бөгөөд хоорондоо уялдаа холбоотой ажилладаг байна. (ОУСК-ийн БОНУТ-ний гарын авлага)


1. Бодлого

2. БОН-ийн эрсдэл, нөлөөллийг тодорхойлох
3. Менежментийн хөтөлбөрүүд
4. Байгууллагын дотоод чадавх, нөөц
5. Яаралтай үед авах арга хэмжээ, бэлэн байдал
6. Оролцогч талуудтай хамтран ажиллах
7. Гадаад харилцаа, санал гомдлын шийдвэрлэх механизм
8. Тайлагнал, ил тод байдал
9. Хяналт, эргэх холбоо

Санхүүгийн байгууллагын БОНУТ нь байгаль орчин, нийгмийн эрсдэлийн удирдлагын бодлого журам (үүнд: БОН-ийн эрсдэлийг ангилал, үнэлгээ, удирдах үйл ажиллагаа хамаарна), БОНУТ-г хэрэгжүүлэх бүтэц, удирдлага зохион байгуулалт, тайлагнал хяналтын механизм зэрэг дараах 7 элементээс бүрддэг.

1. Байгаль орчин, нийгмийн удирдлагын бодлого
2. Төслийн БОН-н эрсдэлийг үнэлэхдээ урьдчилсан үнэлгээ (screen), БОН-н эрсдэлийн түвшний үнэлгээ, болон нарийвчилсан дүн шинжилгээ хийх (due diligence),
3. Мониторинг ба бүртгэл
4. БОНУТ хяналт шалгалт ба тасралтгүй сайжруулалт
5. Гадаад тайлагнал
6. Үүрэг, хариуцлага
7. Төсөв, сургалт, ба ахлах удирдлагын зөвшөөрөл

Зураг 17. Санхүүгийн байгууллагын БОНУТ-ний бүрэлдэхүүн хэсэг



БОНУТ-ний бүрэлдэхүүн хэсгүүдийн бодлого зарчим, процедур, нөөц чадамж, мониторинг ба сайжруулалт, тайлагнал гэсэн хэсгүүдэд хувааж авч үздэг ба энэхүү тогтолцооны суурь элемент нь БОНУ-н талаар баримтлах бодлого томъёолох явдал байдаг.

Байгаль орчин, нийгмийн удирдлагын бодлого

Байгаль орчин, нийгмийн эрсдэлийн удирдлагын бодлого гэдэг нь байгаль орчин, нийгмийн зорилтуудыг тодотгож дүгнэсэн, компанийн амлалт, баримтлах зарчим болон стандартууд юм. Уг бодлого нь байгууллагын бүх оролцогч талуудад ойлгомжтой, байгаль орчин, нийгмийн зорилго, зорилт, үнэ цэнийн талаар нийтлэг ойлголт өгөхүйц байна. БОНУТ-ны бодлогыг бүх үйл ажиллагааг хамарсан, тодорхой салбарт чиглэсэн, эрсдэлийн төрөлд зориулсан зэргээр ялгаатай байдлаар тодорхойлж болно.

Сайтар боловсруулсан бодлого нь дараах шинж чанарыг агуулсан байдаг.

- Тодорхой, бодит, биелэх боломжтой зорилтуудыг тавьсан байх

- БОНУТ-ны хамрах хүрээ, зорилгыг тодорхойлсон байх
- Байгууллагын тэргүүлэх чиглэлийн асуудлыг тодорхойлсон байх
- Товч бөгөөд ойлгомжтой байх
- Бусад холбогдох бодлогуудтай уялдсан, нийцсэн байх
- Бүх оролцогч талуудад ойлгомжтойгоор томъёологдсон байх
- Гүйцэтгэх удирдлагаар баталгаажсан байх

Санхүүгийн байгууллагуудын хувьд БОНУТ-ны бодлогыг боловсруулахдаа дараахыг харгалзан үзэх нь зохистой:

- ТоС-ийн зарчим, шаардлага
- Холбогдох хууль, дүрэм журмын шаардлага
- Олон улсын сайн туршлага
- IFC, EBRD зэрэг олон улсын байгууллагын шаардлага
- Өөрийн байгууллагын онцлог

Санхүүгийн байгууллага нь хуучин бодлогодоо дараах зүйлсийг тусгах хэрэгтэй юм.

- Санхүүгийн байгууллагын явуулж буй бүх үйл ажиллагаа нь байгаль орчин, нийгмийн холбогдох шаардлагуудад нийцэж байх
- Бүх төслийг холбогдох шаардлага, дүрэм журмын дагуу шалгаж хянадаг байх
- БОН-н холбогдох шаардлагад нийцсэн үед нь төслүүдийг санхүүжүүлдэг байх
- Санхүүжүүлсэн бүх төслийг хэрэгжилтийн явцад нь холбогдох байгаль орчин, нийгмийн шаардлагыг хангаж байгаа эсэхэд хяналт тавьдаг байх
- Харилцагч санхүүгийн байгууллагын БОНУТ-ны талаар боловсруулсан бодлого, амлалтыг ойлгодог байх

Жишээлбэл, Монгол улсын ХХБ “Байгаль орчин, нийгмийн хариуцлагын бодлого”-ийн баримт бичигтээ уг бодлогын нийтлэг үндэслэл, зарчим, бодлогын хэрэгжилт болон хяналт, тайлагналын үүрэг хариуцлагуудыг тусгаж, өөрийн цахим хуудастаа байршуулсан байхаас гадна харилцагч нарт зориулсан гарын авлагыг бэлтгэж толилуулсан байна. ХХБ-ны БОНХ-н бодлогын зарим хэсгээс дурдвал:

Жишээ-1

ХХБ-ний БОНХ-ийн бодлогын зорилго

Худалдаа, хөгжлийн банкны байгаль орчин, нийгмийн хариуцлагын бодлогын зорилго нь олон улсын тэргүүн туршлагад нийцүүлэн харилцагчийн байгаль орчин, нийгмийн хариуцлагын эрсдэлүүдийг тодорхойлох, үнэлэх, бууруулах улмаар зээлийн шийдвэр гаргах явцдаа тусган ажиллаж, банкны олгосон санхүүжилт болон харилцагчийн бизнесийн үйл ажиллагаанаас шалтгаалан байгаль орчин, нийгэмд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулахад оршино. Тус бодлого нь банкны БОНХ-ын талаар баримтлах зарчим, удирдлага, хяналтын тогтолцоог тодоройлсон үндсэн баримт бичиг байх ба энэ энэ нь бодлогыг хэрэгжүүлэх заавар журмаар дамжиж хэрэгжинэ хэмээн ХХБ бодлогын баримт бичигтээ дурдсан байна.

ХХБ-ний БОНХ-ийн бодлогын хүрээнд баримтлах зарчим

1. Банк нь хүний эрх, хөдөлмөрийн эрхийн болон байгаль орчны менежментийг үйл ажиллагаандаа сайн хэрэгжүүлдэг харилцагчдыг санхүүжүүлэх чиглэл баримталж, байгаль орчин, нийгэмд үзүүлэх сөрөг нөлөө нь дунд болон өндөр харилцагчдын хувьд үр ашигтай хамтран ажиллах замаар харилцагчийн БОНХ-ын эрсдэлийг бууруулж ажиллана.
2. Банк нь Бодлогыг хэрэгжүүлэх хүрээнд Монгол улсын Байгаль орчныг хамгаалах тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомж, дүрэм зааврыг мөрдөн ажиллахаас гадна олон улсын гэрээ хэлэлцээр, протоколын үзэл баримтлалыг өөрийн үйл ажиллагаа болон санхүүгийн

хэлцэлүүддээ хэрэгжүүлж, мөрдөж ажиллахыг зорино.

3. Банк нь уул уурхай, барилга, боловсруулах салбаруудыг БОНХ-ын илүү их эрсдэл учруулах магадлалтай салбар гэж үзэн доорхи салбаруудад тусгайлан бодлого боловсруулж ажиллана
4. Банк нь ногоон зээл буюу байгаль орчинд ээлтэй зээлийг дэмжин ажиллана.
5. Банк нь “Хориотой үйл ажиллагааны жагсаалт”-д багтсан бүтээгдэхүүн, үйл ажиллагаа, үйл ажиллагааны салбаруудыг санхүүжүүлэхээс татгалзана.
6. Банк нь тогтвортой санхүүжилт олгох зорилтын хүрээнд БОНХ-ын эрсдэлүүдийг тодорхойлох, үнэлэх, бууруулах улмаар зээлийн шийдвэр гаргах явцдаа тусган ажиллана.

Санхүүгийн байгууллагын удирдлага өөрийн байгууллагадаа БОНУТ-ийг нэвтрүүлэхийн тулд байгаль орчин, нийгмийн талаар баримтлах бодлогыг санаачилдаг, манлайлан оролцдог байх хэрэгтэй. Мөн түүнчлэн амжилттай хэрэгжүүлэхийн тулд ажилтнуудад болон бусад оролцогч талуудад таниулах, ойлгуулах, нэгдсэн ойлголт өгөх, хэрэгжилтэнд хяналт тавьж, тасралтгүй сайжруулалт хийх мониторингийн системийг бүрдүүлэх явдал чухал юм.

БОН-ийн бодлогыг санхүүгийн байгууллагын удирдлага батлаж, үйл ажиллагаандаа мөрдүүлдэг байна. Ялангуяа зээлийн ажилтнууд уг бодлогын талаар ойлголттой байхаас гадна харилцагч байгууллагууд ч мөн адил тухайн санхүүгийн байгууллагын БОН-ийн талаар баримтлах бодлогын талаар ойлголт олж авсан байх хэрэгтэй.

БОН-ийн эрсдэлийн удирдлагын журам, процедур

Байгаль орчин, нийгмийн эрсдэлийн удирдлагын журам, процедур нь санхүүжүүлэх аливаа төсөл, хөтөлбөрийн байгаль орчин, нийгмийн эрсдэлийг үнэлэх, удирдах, хянахтай холбоотой чухал баримт бичиг юм. Энэхүү журмыг санхүүгийн байгууллагын удирдлага батлаж, байгууллагын бүхий л үйл ажиллагаанд мөрдүүлдэг байна. Уг журамд

салбар тус бүрээр тохиолдох болзошгүй эрсдэл, эрсдэлийн ангилал, санхүүжүүлэх хориотой болон анхаарах үйл ажиллагааны жагсаалт, эрсдэлийг бууруулах арга хэмжээ, гэрээнд анхаарах нөхцөл, эргэн хяналт, тайлагнал болон байгаль орчин, нийгмийн хамгааллын ажилтан, алба нэгжийн үүрэг хариуцлага зэргийг тусгаж өгсөн байна.

БОНУТ-г хэн, хэрхэн, ямар алхамаар хэрэгжүүлэх, хэрхэн тайлагнах, шийдвэр гаргалтанд хэрхэн тусгах талаар ойлгомжтой, дэс дараалсан, уялдаа холбоог холбогдох журам процедурт тусгасан байх хэрэгтэй. ОУСК-аас санхүүгийн байгууллагын БОНУТ-ны журам, процедурыг боловсруулахад дараах зүйлсийг анхаарахыг зөвлөсөн байна.

| | |
|---------------------------|--|
| Зайлшгүй байх зүйл | <ul style="list-style-type: none"> • “ЯМАР” алхмууд хийгдэхийг дэс дараатай, тодорхой тусгах • Эдгээр алхамуудыг “ХЭН” гүйцэтгэх, хэрэгжүүлэхийг тодорхойлох • Үр дүнг “ХЭРХЭН” процесст тусгах |
| Шаардлагатай зүйл | <ul style="list-style-type: none"> • Бизнесийн орчин • Хөрөнгө оруулалтын цар хүрээ, хэмжээ • Эрсдэлийн түвшин • Шийдвэр гаргах процесс |
| Байвал зохих зүйл | <ul style="list-style-type: none"> • Аль алхамуудыг хэдий хугацаанд хийх буюу хугацааг тусгах • Одоогийн эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаатай уялдуулах |

Эх сурвалж: Sustainability Training, World Bank

Монгол улсын банк, санхүүгийн системд тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг байгаль орчиныг хамгаалах, нийгмийн хариуцлагын тогтвортой бодлогоор дамжуулан нэвтрүүлэхийг санал нэгтгэйгээр дэмжиж 2013 онд “Монгол улсын нийгэм байгаль орчинд ээлтэй Тогтвортой санхүүгийн бодлогыг хөгжүүлэхийн төлөөх хамтын тунхаг бичиг”-т баталж, “Монгол улсын Тогтвортой санхүү (ТоС)-ийн хөтөлбөрийг эхлүүлсэн. Уг хөтөлбөрийн хүрээнд Тогтвортой санхүү (ТоС)-ийн 8 зарчим болон дараах 5 салбарын удирдамжийг боловсруулж, 2015 оноос мөрдөж байна.

- Барилгын салбарын удирдамж
- Уул уурхайн салбарын удирдамж
- Хөдөө аж ахуйн салбарын удирдамж
- Боловсруулах салбарын удирдамж



- Нэхмэлийн салбарын удирдамж

Дээрх удирдамжуудад нь тухайн салбарын БОН-ийн асуудал, тухайн салбарын зээлтэй холбоотой БОН-ийн шаардлага, хяналт шинжилгээ болон тайлагналын асуудлыг багтаасан. Байгаль орчин, нийгмийн эрсдэлийн удирдлагын журам, процедурыг боловсруулахдаа эдгээр зарчим, удирдамжуудыг удирдлага болгох хэрэгтэй.

Эрсдэл, түүний байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөөллийг тодорхойлох

Байгууллагууд өсөж дэвших, амжилтаа хадгалах, аливаа сорилтыг даван туулахын тулд ямар нэгэн байдлаар эрсдэлтэй нүүр тулж байдаг. Дэлхийн уур амьсгалын өөрчлөлт, хууль эрхзүйн тогтворгүй байдал, ханшийн хэлбэлзэл, зээлийн хүүний өсөлт зэрэг олон хүчин зүйл нь эрсдэл үүсэхэд нөлөөлж байдаг.

Хүмүүс эрсдэлийг тодорхойлж, түүнийг ойлгохдоо ихэнхдээ гарз, хохирол, аюул, занал, сөрөг нөлөө, алдагдал зарим тохиолдолд боломж гэж авч үздэг. Эрсдэл гэдэг нь тодорхой бус байдал, учирч болзошгүй гарз хохирол юм.

COSO байгууллагын үзэл баримтлалаар “Эрсдэл гэдэг нь зорилгын биелэлтэд нөлөө үзүүлэхүйц үйл явдлын тохиолдох боломж юм”. Тиймээс санхүүгийн үүднээс авч үзвэл ашиг орлого буурах, оруулсан хөрөнгө оруулалтаа алдах магадлал юм. Тиймээс эрсдэл гэдэг нь гадаад болон дотоод орчны хүчин зүйлээс шалтгаалан байгууллагын үйл ажиллагаанд үзүүлэх сөрөг, тааламжгүй нөлөөлөл юм. Жишээлбэл, COVID-19 цар тахлын улмаас бүх нийтийн хөл хорио тогтооно гэдгийг байгууллагууд урьдчилж мэдээгүйн улмаас бизнесийн үйл ажиллагаа доголдож орлогоо алдах, гэрээ цуцлагдах, төлбөрийн чадвар буурах зэрэг эрсдэл үүсэж болох юм.

Аливаа эрсдэлийн цаана түүнийг үүсгэх шалтгаан байдаг ба эрсдэлийн шалтгаан нь байгалийн болон хүний хүчин зүйлээс хамаарч байдаг.

Хүснэгт 1. Эрсдэлийн шинж чанар

| № | Эрсдэлийн шинж чанар | Тайлбар |
|---|----------------------|---|
| 1 | Тодорхой бус байдал | Эрслэлийг урьдчилан тооцоолох боломж хомс. Эрсдэл үүсгэх үйл явц эсвэл шалтгаан нь тохиолдох магадлалтай байх |

| | | |
|---|---------------------------|--|
| 2 | Хор хохирол учруулдаг | Эрсдэл тохиолдсон бол байгууллагад гарз, хохирол үүсдэг. Тухайлбал ган гачиг ихтэй зун газар тариалангийн компаниуд ургац алдана. |
| 3 | Холбоо хамааралтай байдаг | Эрсдэл нь шалтгаан үр дагавартай байдаг. Эрсдэлийн шалтгаан нь байгалийн эсвэл хүний хүчин зүйл байж болно. Харин үр дагавар нь мөнгөн болон мөнгөн бус гарз хохирол байдаг. |

Эрсдэлийг үүсэх шалтгаан, учрах объект, нөлөөлөх боломж, тохиолдох давтамж, үүсэх үр дагавар зэргээс хамааруулан ангилж болно. Тухайлбал, эрсдэлийг үүсэх шалтгаанаар нь дараах байдлаар ангилдаг. Үүнд:


- Байгалийн хүчин зүйлийн эрсдэл
- Эдийн засгийн эрсдэл
- Улс төрийн хүчин зүйлийн эрсдэл
- Технологийн эрсдэл

Эрсдэлийг хамрах хүрээ, объектоор нэг эсвэл бүлэгт хүмүүст учрах эрсдэл, компанид учрах эрсдэл, улс оронд учрах эрсдэл болон дэлхийн хэмжээнд учрах эрсдэл гэж ангилж болно. Тиймээс байгууллагыг удирдах явцад удирдлага олон төрлийн эрсдэлтэй тулгарч болно. Гэхдээ тэдгээр эрсдэлийг хүлээн зөвшөөрөх, зайлсхийх, бусдад шилжүүлэх эсвэл хяналтыг хэрэгжүүлэх замаар эрсдэлийг бууруулах зэрэг нийтлэг арга замаар удирддаг.

COSO-оос гаргасан Бизнесийн байгууллагын эрсдэлийн удирдлага (Enterprise Risk Management “ERM”) загварыг байгууллагууд нийтлэг ашигладаг. Энэ загвар нь байгууллагын зорилго, зорилтод нөлөөлөх эрсдэлийг тодорхойлж, тэдгээрийн тохиолдох магадлал ба нөлөөллийг үнэлсэнээр эрсдэлд өгөх хариу арга хэмжээг тодорхойлох, эрсдэлийг үнэлэх үйл явцад мониторинг хийх зэрэг асуудлыг багтаасан эрсдэлийн удирдлагын хүрээг тодорхойлоход чиглэсэн байдаг.



Зураг 18. COSO Эрсдэлийн удирдлагын үйл явц



Байгаль орчин, нийгмийн эрсдэл (Environmental and Social Risk) гэдэг нь байгууллагын үйл ажиллагаанаас байгаль орчин болон нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөллийг хэлнэ. Компанийн байгаль орчин, нийгмийн нөлөөллийн эрсдэл нь үйл ажиллагааны төрөл, чиглэл, төслийн онцлог, салбар, газарзүйн байршил, салбарын хууль эрхзүйн орчин зэрэг олон зүйлээс хамаарч харилцан адилгүй байх хэдий ч ихэвчлэн хүний эрүүл мэнд, аюулгүй байдал, олон нийтийн эрх ашиг, тухайн орны биологийн олон төрөл зүйл байдлыг хадгалах, соёлын өвийг хамгаалах зэрэг асуудлуудад төвлөрсөн байдаг.

ОУСК-ийн тодорхойлсоноор компаниуд байгаль орчин, нийгмийн дараах 4 төрлийн эрсдэлтэй нийтлэг тулгардаг. Үүнд:

- Хүрээлэн буй орчины
- Ажлын байрны эрүүл, аюулгүй орчинтой холбоотой
- Хөдөлмөр эрхлэлттэй холбоотой
- Нийгмийн эрүүл мэнд аюулгүй байдалтай холбоотой

Эрсдэл, түүний нөлөөг тооцоогүй, удирдаж чадаагүйгээс компани санхүүгийн, хууль зүйн болон нэр хүндийн эрсдэлд орж болно.

Хүснэгт 2. БОН-н эрсдэлээс шалтгаалан байгууллагад учрах эрсдэл

| Хариуцлагын эрсдэл | Зээл, Санхүүгийн эрсдэл | Нэр хүндийн эрсдэл |
|--|---|--|
| <ul style="list-style-type: none"> • Хуулийн хариуцлага • Иргэний нийгмийн дарамт • Торгууль • Шүүхийн маргаан • Хориг арга хэмжээ /лицензээ алдах/ | <ul style="list-style-type: none"> • Хугацаа хэтэрсэн зээл нэмэгдэх • Чанаргүй зээлийн хэмжээ нэмэгдэх • Барьцаа хөрөнгийн үнэлгээ бууруулах • Төсөл саатах | <ul style="list-style-type: none"> • Нэр хүнд, брэндийн үнэ цэнэ буурах • Харилцагчаа алдах • Зах зээл дэх байр сууриа алдах • Өрсөлдөх чадвар бууруулах |

Жишээлбэл: ОУСК 43 улсын 120 гаруй банк, санхүүгийн байгууллагыг хамруулан хийсэн судалгаагаар “Танай байгууллагад ямар эрсдэл тулгарч байна вэ” гэсэн асуулгад дараах эрсдэлүүд тулгарч байна гэж хариулсан байна.

Зураг 19. Санхүүгийн байгууллагын тодорхойлсон БОН-н гол эрсдэлүүд



Эх сурвалж: IFC

Байгаль орчин, нийгмийн эрсдэлийн нөлөөллөөр (түвшин) нь төслүүдийг **өндөр, дунд, бага эрсдэлтэй** төсөл гэж ангилдаг. Энэхүү ЕСБХБ-наас БОН-ийн эрсдэлийн ангилалыг 2014 онд гаргасан байна.



| Эрсдэлийн түвшин | Тайлбар |
|------------------------|--|
| Өндөр эрсдэлтэй | Харилцагчийн үйл ажиллагаа нь байгаль орчин, нийгэмд урт хугацаанд мэдэгдэхүйц хэмжээнд сөрөг нөлөө үзүүлэхэд хүргэж болно. Сөрөг нөлөө нь өргөн хэмжээний газар нутгийг хамарсан, эрсдэлийг арилгах, бууруулахад хэцүү байх. Өөрөөр хэлбэл, техникийн болон санхүүгийн хувьд хэмжих, үнэлэх боломжгүй. |
| Дунд эрсдэлтэй | Харилцагчийн үйл ажиллагаа нь байгаль орчин, нийгэмд хязгаарлагдмал нөлөө үзүүлж болох ба нөлөөллийг бууруулах арга хэмжээ авах боломжтой, сөрөг нөлөө нь зөвхөн ойр орчмын газар нутгийг хамрах төсөл, үйл ажиллагаа хамаарна. Уг төслийн БОН-ийн эрсдэлийг техникийн болон санхүүгийн хувьд хэмжих, урьдчилан сэргийлэх, бууруулах боломжтой. Уг төслүүдэд ерөнхий үнэлгээ, нарийвчилсан үнэлгээ, газар дээрх шалгалт хийх шаардлагатай байдаг |
| Бага эрсдэлтэй | Байгаль орчин, нийгэмд сөрөг нөлөө багатай төсөл, үйл ажиллагаа. |

Жишээлбэл: ХХБ-ны хувьд олон улсын стандартад нийцсэн арга аргачлалыг ашиглан “Эдийн засгийн салбарын кодчилол”-ын дагуу 322 дэд салбарт ангилан гэрлэн дохионы загвараар **эрсдэлийн үнэлгээг** хийдэг байна.

Хүснэгт 3. ХХБ-ны БОНЭ-ийн ангилал

| Эрсдэлийн ангилал | Эдийн засгийн салбар | |
|--------------------------------|---|----------------------|
| Бага эрсдэлтэй (Ногоон) | Хөдөө аж ахуй, загас агнуур Бөөний болон жижиглэн худалдаа, машины худалдаа Зочид буудал, байр сууц, нийтийн хоолны үйлчилгээ, Мэдээлэл, холбоо Санхүүгийн болон даатгалын үйлчилгээ үйлчилгээ Үл хөдлөх хөрөнгийн үйлчилгээ Боловсрол Урлаг, үзвэр, тоглоом Үйлчилгээний бусад салбар Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн газар | Анхан шатны үнэлгээ |
| Дунд эрсдэлтэй (Шар) | Боловсруулах үйлдвэрлэл Ус хангамж, бохир ус зайлуулах систем, хог хаягдлын менежмент, цэвэрлэх үйл ажиллагаа | Нарийвчилсан үнэлгээ |
| Өндөр эрсдэлтэй (Улаан) | Уул уурхай, олборлолт Барилга Цахилгаа, хий, уур, агааржуулалт | |

ОУСК-аас 2010 онд өөрийн хөрөнгө оруулалтын багцад хийсэн судалгаагаар багцын 35 хувь нь БОН-ийн эрсдэл өндөртэй, эдгээр багцын зээлийн эрсдэл ч мөн адил өндөр байгааг тогтоосон байна. Тиймээс санхүүгийн байгууллагууд нь харилцагчийн болон өөрийн үйл ажиллагааны байгаль орчин, нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөг үнэлж, удирдсанаар санхүүгийн эрсдэл, нэр хүндийн эрсдэлээ удирдах боломжтой болох юм.

Санхүүгийн байгууллагын хувьд байгаль орчин, нийгмийн хүчин зүйлтэй холбоотой эрсдэлийн үнэлгээг дараах дарааллын дагуу гүйцэтгэх ба хэн, хэзээ, хэрхэн эрсдэлийн үнэлгээ хийх талаар БОН-ийн эрсдэлийн удирдлагын журам, процедуртаа тусгаж өгнө. Ингэснээр уг процессийн дагуу хариуцсан ажилтан эсвэл нэгж харилцагчид зээлийн зээл олгохоос өмнө харилцагчийн БОН-ийн эрсдэлийг үнэлж, хариу арга хэмжээ авсанаар БОН-н эрсдэлийн нөлөөллийг бууруулах



боломжтой болно. Санхүүгийн байгууллага нь харилцагчийн байгаль орчин нийгэмд үзүүлэх эрсдэл анхан шатны үнэлгээгээр дунд эсвэл өндөр эрсдэл бол нарийвчилсан үнэлгээг зээлдэгчийн үйл ажиллагаа болон зээлийн зарцуулалтанд хийх хэрэгтэй. Монгол улсын ToC Холбооноос банк, санхүүгийн байгууллагууд зээл олгох, зээлийн үйл ажиллагаанд БОН-н эрсдэлийн дүн шинжилгээ хийх дэс дарааллыг дараах байдлаар боловсруулсан байна.

Зураг 20. Зээлийн үйл ажиллагаанд байгаль орчин, нийгмийн асуудлыг авч үзэх процесс



Банк, санхүүгийн байгууллагууд хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомж, олон улсын гэрээнд нийцүүлэн, олон улсын хэмжээнд хориглосон, мөн хөрөнгө оруулагчдаас тавьсан шаардлагын хүрээнд “Санхүүжүүлэхийг хориглосон үйл ажиллагааны жагсаалт”-ыг тодорхойлж, мөрдөж ажиллах ёстой.



Шигтгээ 4: Тогтвортой санхүүжилтийн зарчмуудын хавсралт

Санхүүжүүлэхийг хориглосон үйл ажиллагааны жагсаалт

1. Монгол Улсын болон бусад гадаад улсын хууль, Монгол улсын нэгдэн орсон олон улсын конвенци, гэрээ хэлцлийн дагуу хориглосон үйл ажиллагаа;

2. Хуулинд тусгагдаагүй сэтгэцэд нөлөөлөх ургамлын тариалан, үйлдвэрлэл, тээвэрлэлт болон мансууруулах бодисын худалдаа;
3. Хууль бус мөрийтэй тоглоом, казиногийн бизнес;
4. Садар самуун явдлыг сурталчлах, дэмжих, зохион байгуулах;
5. Албадан хөдөлмөрийн мөлжлөгийн хэлбэр, хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэр, ялгаварлан гадуурхал, хуульд заасан ажиллагсдын эвлэлдэн нэгдэх, хамтын хэлэлцээр байгуулах эрхийн хязгаарлалт;
6. Буу зэвсгийн үйлдвэрлэл, худалдаа;
7. Олон шатлалтай маркетинг, пирамидын сүлжээгээр ашиг олох;
8. Тухайн улс орнуудаас тогтоосон тусгай зөвшөөрөл, лицензийг авалгүй улс хооронд эрхлэх экспортын худалдаа, импортын худалдаа, гадны хөлөг ашиглан хийх худалдаа;
9. Олон улсын болон үндэсний хамгаалалттай бүсийн ойролцоо үйл ажиллагаа явуулах;
10. Биологийн олон янз байдал, түүх, соёлын өвийг хамгаалах олон улсын конвенци, гэрээ хэлцлийн дагуу хориглосон үйл ажиллагаа;
11. Асбест болон түүний нэгдлийг агуулсан бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, худалдах, ашиглах;
12. Полифлорт дифенил агуулсан аливаа бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдаа;
13. Озоны давхарга задалдаг олон улсад хориглосон бодис агуулсан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдаа;
14. Олон улсад хориглосон эм тариа, шахмал эм, хортон шавж устгадаг болон бусад хорт бодисын үйлдвэрлэл, худалдаа;

15. Байгалийн нэн ховордсон зэрлэг амьтан, ургамлын олон улсын конвенциор хориглосон байгалийн зэрлэг амьтад, ургамлын төрөл зүйлийн худалдаа;
16. Байгаль орчинд сөрөг нөлөөтэй аргаар загасчлах (тэсрэх бодис ашиглан загасчлах гэх мэт)
17. Олон улсад хориглосон хог хаягдлын тээвэрлэлт, устгал;
18. Ач холбогдол бүхий ойн бүсэд эрхлэх модны үйлдвэрлэл (хангайн бүс), тусгай хамгаалалтын газрын ойролцоох мод болон мод бэлтгэлийн тоног төхөөрөмжийн худалдаа;
19. Тогтвортой менежменттэй ойн бус үүсэл гаралтай мод, ойн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдаа;

Санхүүгийн байгууллагын холбогдох ажилтан харилцагчийн болон төслийн байгаль орчин, нийгмийн нөлөөллийн эрсдэлийг тодорхойлох, анхан шатны үнэлгээ нь харилцагчийн зээлийн хүсэлтийг хүлээн авах үе шатанд хийгдэнэ. Санхүүгийн байгууллага нь анхан шатны үнэлгээгээр тухайн харилцагч болон санхүүжүүлэх төслийн үйл ажиллагаа нь байгаль орчин болон нийгэмд ямар нэг байдлаар сөрөг нөлөө үзүүлэх эсэхийг тодруулах шаардлагатай. Хэрэв харилцагч болон санхүүжүүлэх төслийн үйл ажиллагаа нь “Санхүүжүүлэхийг хориглосон үйл ажиллагааны жагсаалт”-д багтсан бол зээлийн хүсэлтийг буцаах эсвэл судлахаас татгалзах үүрэгтэй байдаг. Харин “Санхүүжүүлэхийг хориглосон үйл ажиллагааны жагсаалт”-д багтаагүй боловч өмнө нь байгаль орчин, нийгэмд сөрөг нөлөө үзүүлж байсан эсвэл одоо болон ирээдүйд эрсдэлд оруулж болзошгүй эсэхийг анхаарах үзэх хэрэгтэй. Тухайлбал, Монгол улсын бүх арилжааны банкууд 50 сая төгрөгөөс дээш, 12 сараас дээш хугацаатай бүх бизнесийн зээлийн хүсэлтийг БОН-н эрсдэлийн үнэлгээг хийж байна. Мөн түүнчлэн “Санхүүжүүлэхийг хориглосон үйл ажиллагааны жагсаалт”-д багтсан үйл ажиллагаа биш бол, тухайн бизнес нь **“Анхаарах шаардлагатай үйл ажиллагааны жагсаалт”**-д хамаарах эсэхийг шалгаж, үргэлжүүлэн судлах шаардлагатай эсэхийг тодорхойлох хэрэгтэй.

Шигтгээ 5: Тогтвортой санхүүжилтийн зарчмуудын хавсралт

Анхаарах үйл ажиллагааны жагсаалт

1. Иргэдийг албадан нүүлгэн суурьшуулахтай холбоотой аливаа үйл ажиллагаа;
2. Тухайн орон нутгийн иргэдийн амьжиргаанд шаардлагатай газрын маргаантай, тусгай хамгаалалттай газар нутагтай ойролцоо явагдах аливаа үйл ажиллагаа, устах аюулд орсон, устаж болзошгүй биологийн олон янз байдлын төрөл зүйлийн унаган тархац нутагт болон экологи, эдийн засгийн хувьд чухал газар нутагт явагдах аливаа үйл ажиллагаа;
3. Археологи, түүх ба соёлын дурсгалыг устгаж гэмтээж болзошгүй үйл ажиллагаанууд;
4. Хувирсан амьд организмыг худалдаалах, нутагшуулах;
5. Цөмийн эрчим хүч (уран олборлох, боловсруулах, баяжуулах, цөмийн түлш хадгалах, тээвэрлэх, цөмийн эрчим хүч түгээх);
6. Цацраг идэвхит бодис үйлдвэрлэх, худалдаалах ба цацраг идэвхит хаягдлыг хадгалах, тээвэрлэх;
7. Газрын тос, байгалийн хийн томоохон төслүүд мөн байгалийн хий дамжуулах хоолойн барилга;
8. Өнгөт болон өнгөт бус металлын олборлолтын томоохон төслүүд;
9. Усан цахилгаан станц ба дулааны станцын барилга;
10. Ахуйн хог хаягдал ба аюултай хог хаягдалын устгал;
11. Хөдөлмөрийн нөхцөл, эрүүл мэндэд ихээхэн сөрөг нөлөөлөл үзүүлэх аливаа төслүүд, нийгэм, эдийн засагт сөрөг нөлөөлөл үзүүлэх аливаа төслүүд;
12. Шар айраг, дарснаас бусад архи согтууруулах ундаа ба тамхины үйлдвэрлэл ба худалдаа.

Харилцагчийн үйл ажиллагаа нь дээрх анхаарах үйл ажиллагааны жагсаалтад багтаагүй ч БОН-ийн эрсдэлийг үргэлжлүүлэн тодорхойлох үүднээс харилцагчийн бизнесийн үйл ажиллагаа нь эдийн засгийн салбарын ямар ангилал, дэд ангилалд хамаарахыг тодорхойлох дараагийн арга хэмжээг авч болно. Тухайн харилцагчийн бизнесийн эдийн засгийн салбар, дэд ангилалыг зөв тодорхойлсноор тухайн салбартай холбоотой бизнесийн үйл ажиллагааны эрсдэлийг зөв тодорхойлох боломжтой болно.

Иймд санхүүгийн байгууллагууд нь харилцагчийн болон санхүүжүүлэх төслийн үйл ажиллагааны БОН-ийн нөлөөлөл, эрсдэлийг үнэлэх эрсдэлийн удирдлагын журам, процедураа ТоС-ийн заавар болон олон улсын стандартад нийцүүлэн боловсруулж, мөрдөх хэрэгтэй.

БОНУ-н Бүртгэл, Тайлагнал

Санхүүгийн байгууллага нь хөрөнгө оруулалтын багц эрсдэл, төсөл бүрийн БОН-ийн эрсдэл, төслийн БОН-ийн эрсдэлийн талаар авч хэрэгжүүлсэн ажлын явц, эрсдэлийн үнэлгээ, төслийн хяналт, үл нийцэл, залруулах арга хэмжээ, үр дүнг оролцогч талуудад тайлагнадаг байна. Хэрхэн, хэзээ, хэнд тайлагнах процедурыг БОНУТ-ны бодлого, журамдаа тусгаж өгсөн байх хэрэгтэй. БОНУ-н тайлагналыг **гадаад тайлагнал** ба **дотоод тайлагнал** гэж ангилж авч үздэг. Гадаад тайлагналыг хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагч, зохицуулагч байгууллага болон олон нийтэд зориулан бэлтгэдэг бол дотоод тайлагнал нь байгууллага өөрийн удирдлага болон ажилтнуудын хэрэгцээнд зориулан бэлтгэдэг. Гадаад болон дотоод тайлагналд дараах зүйлсийг анхаарах хэрэгтэй.

Дотоод тайлагналын хувьд:

- Тайлангийн давтамжийг тодорхойлох
- Тайлан хүлээн авах удирдлагыг тодорхойлох
- Тайланд тусгах мэдээллийг тодорхойлох
- Жилийн тайланд оруулах мэдээллийг тодорхойлох

Гадаад тайлагналын хувьд:

- БОНУТ-ын хэрэгжилттэй холбоотой хууль, журмаар үүрэг хүлээсэн тайлан, мэдээллүүд

- Эрсдэлийн үнэлгээтэй холбоотой тайлан
- БОН-ийн тулгарч байгаа асуудлууд, оролцогч талууд
- Салбар, өрсөлдөгчдөд тулгарч буй асуудал, сорилтууд
- Хууль, зохицуулалт, олон улсын стандарт, гэрээ хэлэлцээр

Санхүүгийн байгууллагын хувьд БОНЭ-ийн үнэлгээ хийгдсэн төсөл болон өөрийн дотоод экологийн ул мөртэй холбоотой дараах мэдээллийг бүртгэж, оролцогч талуудад тайлагнах байх хэрэгтэй.

- БОНЭ-ийн үнэлгээ хийгдсэн зээлийн тоо, хэмжээ
- Санхүүжүүлэхээс татгалзсан зээлийн тоо
- Санхүүжүүлсэн ногоон төслийн зээлийн тоо, хэмжээ
- Ногоон санхүүжилт, үйл ажиллагааны талаар харилцагч талуудад мэдээлэл өгсөн байдал
- Дотоод экологийн ул мөр гэх мэт

Монгол улсын банкны салбарын хувьд ТоС-ийн сайн дурын тайлагналын тогтолцоог анх Монголын банкуудын холбооноос ТоС Хөтөлбөрийг дэмжигч олон улсын байгууллагуудтай хамтран бий болгосон байдаг. Одоогийн байдлаар бүх арилжааны банкууд хагас жил тутамд ТоС Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн ажлаа дүгнэн тайлан бэлдэж, ТоС Холбоонд илгээж байна. Мөн зарим банкууд ТоС Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн ажлаа өөрийн цахим хуудас, жилийн тайлан, нийгмийн хариуцлагын тайлан болон тогтвортой хөгжлийн тайлан бэлтгэн ил тод, нээлттэй тайлагнах тогтолцоог бий болгон ажиллаж байна. Жишээлбэл, Хаан банк 2018 оноос эхлэн “Тогтвортой хөгжлийн тайлан” бэлтгэн гаргаж байна. Тус банкны 2019 оны тайландаа ногоон зээл, БОН-н эрсдэлийн үнэлгээ хийсэн зээлийн хэмжээ, дотоод экологийн ул мөрийг багасгах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн зэргийг тайлагнасан байна.

ОУСК 2014 онд 9 улсын 123 санхүүгийн байгууллагыг хамруулан БОНУТ-ны хэрэгжилтийн түвшинг бодлого, процедур, дагаж мөрдөж буй стандарт, хүний нөөц, шийдвэр гаргалтад ашиглаж буй байдал гэсэн чиглэлээр тодорхойлох судалгаа хийсэн. Уг судалгааны тайланд дурдсанаар хөгжлийн банкууд болон олон улсын санхүүгийн байгууллагуудтай хамтарч ажилладаг санхүүгийн байгууллагуудын



хувьд БОНУТ-ийг хэрэгжүүлсэн байдал харьцангуй сайн бол бусад санхүүгийн байгууллагын хувьд харилцан адилгүй ялгаатай байна. Ялангуяа судалгаанд хамрагдсан байгууллагуудын 47% нь БОНУ-ийн журамтай, 37% нь хариуцсан нэгжтэй, 33% нь албан ёсны бодлоготой, 33% нь тогтвортой байдлын жилийн тайлан бэлтгэдэг, 15% нь ажилтнуудаа урамшуулах хөтөлбөртэй үр дүн гарсан байна. Харин манай улсын хувьд Тогтвортой санхүүгийн холбооны зүгээс 2016 оны байдлаар БОНУТ-ийн хэрэгжилтийн байдлыг гишүүн банкуудын хувьд дараах байдлаар гаргасан байна.

| № | БОНУТ-ийн хэрэгжилт | Банкны тоо |
|---|---|------------|
| 1 | ТоС-ийн бодлого, журам | 14 |
| 2 | ТоС хариуцсан орон тоо | 11 |
| 3 | Хориглосон үйл ажиллагааны жагсаалт | 14 |
| 4 | ТоС-ийн эрсдэлийн үнэлгээ | 14 |
| 5 | ТоС-ийн эрсдэлийг бууруулах арга хэмжээ | 14 |
| 6 | Тайлагнал | 14 |

Дээрхээс харвал банкуудын хувьд БОНУТ-ийг аль хэдийн нэвтрүүлэн үйл ажиллагаандаа хэрэгжүүлж байна гэж дүгнэж болохоор байна. Харин ББСБ-уудын хувьд бидний судалгаанаас харахад БОНУТ-ний хэрэгжилт сул, дийлэнх нь БОНУТ-г хөгжүүлээгүй, нэвтрүүлээгүй байна гэж хэлж болохоор байна. Мөн ОУСК-н БОНУТ-ийн хэрэгжилтийн талаарх судалгааны тайлан, бусад улс орнуудын туршлагаас харахад санхүүгийн байгууллагууд эрх бүхий зохицуулагч байгууллагуудаас БОНУТ-г хөгжүүлж, нэвтрүүлэх талаар тодорхой заавар, удирдамжуудыг хүлээж байдаг талаар дурдсан байна. Мөн тодорхой бус зохицуулалт нь БОНУТ-г нэвтрүүлэхэд саад болж байдаг гэж үзсэн байна. Иймд ОУСК-аас хөгжиж буй улс орнуудын санхүүгийн байгууллагуудын хувьд БОНУТ-г амжилттай нэвтрүүлэхэд зохицуулагч байгууллагаас гаргах БОНУТ-ний талаарх заавар аргачлал маш чухал үзсэн байна.

БАЙГАЛЬ ОРЧНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙГ ҮНЭЛЭХ НЬ

Энэ сэдвийн хүрээнд дараах зүйлсийн талаар судлах болно. Үүнд:

- Байгаль орчны гүйцэтгэлийг үнэлэх хэрэгцээ шаардлага
- Ногоон индекс юуг хэмждэг вэ?
- Ногоон индексийн зорилго, хэрэглээ
- Ногоон индексийг хэмжих аргагүй

3.1 БАЙГАЛЬ ОРЧНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙГ ҮНЭЛЭХ ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА

Уур амьсгалын өөрчлөлт, байгалийн нөөцийн шавхагдал, агаарын бохирдол болон хог хаягдал зэрэг нь дэлхийн нийтийн өмнө тулгамдаж буй байгаль орчны асуудал болж байна. Ялангуяа энэхүү асуудал нь бичил санхүүгийн салбарын хувьд анхаарах чухал асуудлуудын нэг болсоор байна. “Ногоон бичил санхүү” гэсэн ойлголтыг дэмжигчид, судлаачид бичил санхүү нь бусад бизнесүүдийн адил байгаль орчныг хамгаалах, байгаль орчны эрсдэлийг бууруулах талаар тодорхой үйлдэл хийдэг, хариуцлага хүлээдэг байх ёстой гэж үзэж байна. Зарим бичил санхүүгийн байгууллагууд санхүүгийн болон нийгмийн тулгуур шугамаас гадна аль хэдийн байгаль орчны гүйцэтгэлийг анхааралдаа авч эхлээд байгаа боловч энэхүү “ашиг, хүн, эх дэлхий” гэсэн гурван тулгуурт шугам нь бичил санхүүгийн салбарын шинэ ойлголт хэвээр байна.

Бичил санхүүгийн байгууллагын байгаль орчны гүйцэтгэлийг хэрхэн хэмжих болон бичил санхүүгийн байгууллагын хэмжээ, санхүүгийн байдал, үйл явуулсан хугацаа нь байгаль орчны гүйцэтгэлд нөлөөлдөг эсэх талаар эрдэмтэн Мэрион Аллет анх удаа 2011 онд дэлхийн 160 бичил санхүүгийн байгууллагыг хамруулсан судалгааг хийсэн ба түүний судалгаагаар 78 хувь нь байгаль орчныг хамгаалах үүрэгтэй гэж үзсэн байна (Allet, 2012). Гэсэн хэдий ч судалгаанд хамрагдсан бичил санхүүгийн байгууллагуудын дийлэнх нь хараахан байгаль




орчныг хамгаалах энэхүү зорилгодоо хүрэхийн тулд ямар стратеги баримтлахаа мэдэхгүй байна.

Мөн түүнчлэн бичил санхүүгийн хөрөнгө оруулагчид бичил санхүүгийн байгууллагуудын байгаль орчны гүйцэтгэлийг мэдэх сонирхолтой байгаа улмаар байгаль орчны гүйцэтгэл сайн бичил санхүүгийн байгууллагуудад хөрөнгө оруулалт хийх сонирхол улам бүр нэмэгдэж байна. Гэвч бичил санхүүгийн байгууллагууд өөрсдийн байгаль орчны гүйцэтгэлээ хэрхэн хэмжих, хянаж үнэлэхээ мэдэхгүй байгаа гэж судлаачид үзэж байна.

SYMBIOTICS MIV SURVEY 2019 судалгааны тайлангаас харахад байгаль орчны гүйцэтгэлийг хөрөнгө оруулалтын шийдвэр гаргалтад авч үзэж буй байдал 78 хувьтай буюу сүүлийн 5 жилийн хувьд тогтвортой хэвээр байна (Symbiotics, 2019).


Зураг 21. Хөрөнгө оруулалтын шийдвэр гаргалтад байгаль орчны асуудлыг анхаарсан оролцогчийн хувь.



Эх сурвалж: Symbiotics MIV survey 2019

Мөн бичил санхүүгийн байгууллагуудын ногоон гүйцэтгэлийн үзүүлэлт (Зураг 20) болон ногоон бичил санхүү сүүлийн жилүүдэд өсөж байгааг MIX Market-ийн судалгааны тайлангаас харж болно.


Зураг 22. MIX Market: Ногоон гүйцэтгэлийн тайлагнал



Эх сурвалж: MIX market


Доорх зургаас харахад Африк тив ногоон зээлийн бүтээгдэхүүнтэй бичил санхүүгийн байгууллага олонтой болох нь харагдаж байна. Харин Европ болон Төв Азийн улсуудын хувьд дундаж хэмжээнд байна.

Зураг 23. Ногоон зээлийн бүтээгдэхтэй БСБ-дын тоо бүс нутгаар




Олон улсад Mixmarket, MicroFinanza, PlaNet, CERISE SPI4 зэрэг бичил санхүүгийн байгууллагын рэйтинг тогтоодог байгууллагууд санхүүгийн гүйцэтгэл, нийгмийн гүйцэтгэл болон байгаль орчны гүйцэтгэлийн индексийг тодорхойлох замаар үнэлгээ хийж, рэйтинг тогтоож байна. Тухайлбал, MicroFinanza Rating тогтоогч байгууллага 2007-2015 оны хооронд 47 улсын бичил санхүүгийн байгууллагын гүйцэтгэлийн индексийг тодорхойлсон. Уг судалгааны үр дүнгээс харахад бичил санхүүгийн байгууллагын 41 хувь (Зураг 24) нь ногоон индексийн үзүүлэлтээр дундаж үнэлэгдсэн бол энэхүү ногоон индексийн үзүүлэлт нь санхүүгийн болон нийгмийн гүйцэтгэлийн үзүүлэлтээс доогуур буюу сул байгаа ажиглагдсан (График 25).

Зураг 24. MicroFinanzaRating: Ногоон индексийн гүйцэтгэл БСБ-ийн хувь



Зураг 25. Байгаль орчин, нийгэм, санхүүгийн гүйцэтгэлийн харьцуулалт



3.2 БАЙГАЛЬ ОРЧНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙГ ҮНЭЛЭХ АРГАЗҮЙ

2010 оноос эхлэн бичил санхүүгийн байгууллагын байгаль орчны гүйцэтгэлийг хэмжих оролдлого хийгдэж байгаа бөгөөд бичил санхүүгийн байгууллагууд нь өөрсдийн байгаль орчны гүйцэтгэлийг

хэмжсэнээр байгаль орчны талаар баримтлах бодлого, стратегиа тодорхойлох болон дотоод процессоо сайжруулах боломж бүрдэх юм.

Гэсэн хэдий ч одоог хүртэл нэгдсэн тогтсон аргагүй байхгүй хэвээр байгаа 2011 оноос хойш дэлхийн улс орнуудын бичил санхүүгийн байгууллагуудын байгаль орчны гүйцэтгэлийг хэмжиж, харьцуулан судалсан үндсэн 2 аргагүй байна. Үүнд:

Бичил санхүүгийн байгууллагын байгаль орчны гүйцэтгэлийн индекс-БСББОГИ (MEPI):

Судлаач Мэрион Аллет “**Measuring Environmental performance Index- MEPI**” гэсэн бичил санхүүгийн байгууллагын байгаль орчны гүйцэтгэлийг хэмжих 5 шалгуур, 18 үзүүлэлт бүхий аргагүйг боловсруулсан (Allet, 2012). Энэхүү аргачлал нь дараах 5 шалгуураар хүрээнд хүрээнд байгаль орчны гүйцэтгэлийг хэмждэг. Үүнд:

- Байгаль орчны бодлого, стратегийг хэрэгжүүлж буй байдал
- Дотоод экологийн ул мөрийг бууруулж буй байдал
- Багцын байгаль орчны эрсдэлийг удирдаж буй байдал
- Ногоон бичил зээл олгож буй байдал
- Байгаль орчны санхүүгийн бус үйлчилгээ үзүүлж буй байдал

Бичил санхүүгийн байгууллагууд нь байгаль орчны асуудлыг дараах стратегиар дамжуулан шийдвэрлэж байна.

Стратеги 1. Байгаль орчны бодлогыг хэрэгжүүлэх

Энэ нь хамгийн түгээмэл хэрэгжиж байгаа ба ялангуяа бизнесийн алсын хараа, эрхэм зорилго, үнэ зүйл, бодлого журамдаа байгаль орчны асуудлыг шигтгэх оруулж байна. Тухайлбал, Хас банк эрхэм зорилгодоо “Эрдэнэт хүмүн, Эх дэлхий, Эрүүл ашгийг эрхэмлэн харилцагчиддаа үнэ цэнтэй санхүүгийн үйлчилгээг хүргэж, насан туршийн түнш байх” гэж тодорхойлсон байна. Ингэснээр байгаль орчны хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх үзэл баримтлал, суурь нь бүрдэх боломж бүрдэж байна. Энэхүү стратеги нь байгаль орчны үйл ажиллагаа, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх суурь нь юм.

Стратеги 2. Дотоод экологийн ул мөрийг бууруулах



Бусад бизнесүүдийн адил, байгаль орчны гүйцэтгэлээ сайжруулахыг зорьж байгаа БСБ-үүд өөрийн үйл ажиллагааны дотоод ул мөрийг бууруулах талаар тодорхой үйл ажиллагаа хэрэгжүүлж, хэмжиж улмаар оролцогч талуудад тайлагнаж байна. Тухайлбал, Камбожулсын ACLEDA, монгол улсын Хас банк, Хаан банк зэрэг байгууллагуудыг дурдаж болно. Хаан банкны хувьд 2019 онд цаасгүй үйлчилгээг нэвтрүүлсэнээр 2,5 сая хуудас цаас буюу 5 тн модыг эх дэлхийдээ үлдээсэн талаар 2019 оны жилийн тайландаа тусгажээ.

Стратеги 3. Байгаль орчны эрсдэлийг удирдах

Мөн БСБ-ууд өөрийн дотоод экологийн ул мөрийг бууруулах стратеги барихаас гадна харилцагчийн түвшинд байгаль орчны нөлөөлөл, асуудалд анхаарал хандуулах стратеги баримталж болно. Энэ стратеги нь харилцагчийн үйл ажиллагаанаас үүсэх байгаль орчны эрсдэлийг удирдах болон хор нөлөө ихтэй үйл ажиллагааг санхүүжүүлэхээс зайлсхийх явдал юм. Тиймээс, олон улсад БСБ-ууд үндэсний болон олон улсын стандарт, шаардлагуудад нийцүүлэн санхүүжүүлэхийг хориглосон үйл ажиллагааны жагсаалтыг боловсруулж зээл олгох үйл ажиллагаандаа ашиглаж байна. Манай улсын хувьд 2015 оноос хойш арилжааны банкууд БОНУТ-г нэвтрүүлж эхлээд болно. Тухайлбал, Хаан банк 2019 оны Тогтвортой хөгжлийн тайландаа нийт 191 зээлдэгчийн 306,9 тэрбум төгрөгийн зээлийн хүсэлтэд БОНЭ-ийн үнэлгээ хийсэн гэж тусгажээ.

Стратеги 4. Ногоон зээл олгох

БСБ-ууд нь харилцагчийн үйл ажиллагааны БОНЭ-г үнэлэхээс гадна байгаль орчинд илүү ээлтэй бүтээгдэхүүн, үйл ажиллагааг дэмжихэд чиглэсэн санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээг хөгжүүлж байна. Зарим БСБ-ууд а/ байгаль орчинд ээлтэй орлого олох үйл ажиллагааг хөгжүүлэхэд чиглэсэн (хог хаягдалын менежмент, эко аялал жуулчлал гэх мэт), б/ байгаль орчинд ээлтэй технологи (сэргээгдэх эрчим хүч, эрчим хүчний хэмнэлттэй халаагуур, сууц гэх мэт)-ийг дэмжихэд чиглэсэн ногоон зээлийн бүтээгдэхүүн үйлчилгээг хөгжүүлж байна. Ингэснээр БСБ-ууд нь зах зээлээ тэлэх, бүтээгдэхүүн үйлчилгээг төрөлжүүлэх замаар байгаль орчны асуудлыг шийдвэрлэх боломжтой юм. Тухайлбал, Хас банк хувьд уур амьсгалын өөрчлөлтийг сааруулахад бодитой хувь нэмэр оруулах үүднээс хүлэмжийн хийг бууруулах зорилгоор бүхий зээлийн бүтээгдэхүүн үйлчилгээг үзүүлж байна.

Стратеги 5. Байгаль орчны санхүүгийн бус үйлчилгээ үзүүлэх

БСБ-уудын үндсэн үйл ажиллагаа нь санхүүгийн үйл ажиллагаа боловч зарим нь байгууллагууд санхүүгийн бус байгаль орчинд чиглэсэн үйлчилгээг хөгжүүлэхийг зорьж байна. Энэ нь уламжлалт банкны салбаруудад түгээмэл ашиглагддаг. Зарим БСБ-ууд санхүүгийн бус үйлчилгээг санхүүгийн үйлчилгээний адил чухал гэж үздэг ба ихэвчлэн харилцагчдын санхүүгийн мэдлэг, ойлголтыг тэлэх, сургалт, олон нийтийн үйл ажиллагааг явуулдаг байна. Арилжааны банкуудын хувьд тогтвортой хөгжил, нийгмийн хариуцлагын хүрээнд олон нийт болон харилцагчдын санхүүгийн боловсролыг нэмэгдүүлэх, тогтвортой хөгжлийг дэмжих зорилго бүхий үйл ажиллагаануудыг хэрэгжүүлж байна.

Энэ нь байгаль орчныг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулахад шууд бусаар нөлөө үзүүлэхээс гадна, бичил санхүүгийн байгууллагуудын нэр хүндийг нэмэгдүүлэх, мөн тэдэнд зах зээлээ тэлэх боломжийг олгодог байна.

Ногоон индекс 2.0

Ногоон индекс 2.0 аргачлал нь E-MFP-ийн ажлын хэсгээс анх 2014 онд боловсруулсан (58 гишүүн, 41 байгууллага). 2016 онд уг аргачлалыг сайжруулж 2 дахь хувилбарыг нийтэд танилцуулсан. Энэхүү аргачлалыг одоогийн байдлаар SPI4, MicroFinanza Social Rating, Ali-nus зэрэг рэйтинг тогтоох болон нийгмийн аудитын хэрэгслүүдэд ашигладаг. БСБ-уудын байгаль орчны гүйцэтгэлийг үнэлж, удирдах хамгийн хүлээн зөвшөөрөгдсөн аргачлал юм (Group, 2016).

Ногоон индекс 2.0 аргачлал нь **чанарын болон тоон үзүүлэлт** үндсэн 2 бүрэлдэхүүн хэсэгтэй ба тоон үзүүлэлтүүдийг багтаасан тул MEPI аргачлалаас илүү давуу талтай юм. Тус аргачлалын чанарын үзүүлэлтийн хувьд дараах 4 шалгуур үзүүлэлтээр байгаль орчны гүйцэтгэлийг үнэлдэг. Үүнд:

- **Стандарт 1:** БСБ-ын байгаль орчны стратегийг тодорхойлж, удирдаж, хянадаг байдал;
- **Стандарт 2:** Байгаль орчны дотоод эрсдэлийг удирддаг байдал;
- **Стандарт 3:** Энэ нь байгаль орчны гадаад эрсдэлийн удирддаг байдал;
- **Стандарт 4:** БСБ-ууд хэрхэн ногоон боломжуудыг дэмждэг байдал



Энэхүү ногоон индекс аргачлалын зорилго:

- БСБ-уудын байгаль орчны хариуцлага болон гурван тулгуурт хандлагыг хөгжүүлэх;
- Ногоон үзүүлэлтийг БСБ-ын гүйцэтгэлийн үнэлгээний хэрэгсэлд (тухайлбал, нийгмийн гүйцэтгэлийн удирдлагын хэрэгсэл) нэгтгэхийг сурталчилах;
- БСБ эсвэл бусад хүртээмжтэй санхүүгийн байгууллагуудын баталж, хэрэгжүүлэх боломжтой байгаль орчны үндсэн стратегийг толилуулах замаар сурган хүмүүжүүлэх арга барилтай болох.

Энэхүү ногоон индекс аргачлалын ач холбогдол, хэрэглээ:

БСБ-ууд, болон бусад санхүүгийн байгууллагуудын хувьд (удирдлага, ажилтан):

- Байгаль орчны одоогийн нөхцөл байдлыг үнэлэх
- Байгаль орчны өөрийн нөхцөл байдлыг бусад байгууллагуудтай харьцуулах
- Байгаль орчинтой холбоотой өөрсдийн стратегиа тодорхойлох
- Цаг хугацааны туршид байгаль орчны гүйцэтгэлийн ахиц дэвшлийг хянах
- Байгаль орчны гүйцэтгэлийн талаар харилцах

Хөрөнгө оруулагч болон бичил санхүүгийн зэрэглэл тогтоох байгууллагуудын хувьд:

- БСБ-уудын байгаль орчны гүйцэтгэлийн талаар ойлголт олж авах;
- Хөрөнгө оруулалт хийх зорилготой байгууллага болон бүх БСБ-уудын хувьд нийтлэг тайлагналын хэрэгсэлтэй болох ба улмаар бэнчмарк хийх, ахиц дэвшлийг үнэлж хянах боломжтой болно.


Мэргэжлийн байгууллага, холбоод болон техник тусалцааны байгууллагуудын хувьд:

- БСБ-уудын байгаль орчны гүйцэтгэлийг сайжруулахын тулд зөрүүг тодорхойлох, шаардлагатай дэмжих үйлчилгээг хөгжүүлэх;

- Тэдний дэмжлэг үзүүлэх үйлчилгээ нь БСБ-ууд эсвэл бусад санхүүгийн байгууллагуудын байгаль орчны гүйцэтгэлийг сайжруулахад хэрхэн тусалж байгааг үнэлэхэд хэрэгтэй.

БСБ-уудын байгаль орчны гүйцэтгэлийг дээрх аргачлалуудыг ашиглан 2011 онд хөгжиж буй улсын 160 БСБ (Allet, 2011), 2013 онд Европын 59 БСБ (Forcella, 2014), 2014 онд Төв Америкийн улсуудын 53 БСБ (Passerelles, 2014)-г хамруулан байгаль орчны гүйцэтгэлийг үнэлсэн. Харин бид Монгол улсын 263 БСБ-ын байгаль орчны гүйцэтгэлийг “Ногоон индекс 2.0” аргачлалаар 2020 оны 6-8 сарын хооронд үнэлсэн ба судалгааны үр дүнд БСБ-уудын **ногоон индекс 15 хувь буюу маш сул** үнэлэгдсэн (А.Одгэрэл, 2020).

Зураг 26. БОНГ-ийн үнэлгээний харьцуулалт



Эх сурвалж: БСБ-ийн ногоон санхүүжилтийн өнөөгийн байдал судалгааны тайлан

Дээрх үнэлгээнээс манай улсын бичил санхүүгийн байгууллагуудын байгаль орчны гүйцэтгэл сул байна гэж харагдсан. Иймд бичил санхүүгийн байгууллагууд нь өөрийн байгаль орчны гүйцэтгэлээ сайжруулах, байгаль орчны асуудлаар ямар бодлого, стратеги тодорхойлох, хэрэгжүүлэх вэ гэдгээ шийдвэрлэхийн тулд нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн “Ногоон индекс 2.0” аргазүйг ашиглан өөрийн үнэлгээг хийж болно. Мөн “Ногоон индекс 2.0” аргачлалын асуулга болон үнэлгээний заавар болон жишээг хавсралтаар харууллаа.



АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- С.Дашдорж. (2019). Тогтвортой санхүү. хороо, Ү. с. (2020). Global Development Goals. From sdg.1212.mn
- МБ, СЗХ, СЯ, ХДК. (2019). “Ногоон таксономи”-ийг батлах тухай хамтарсан тушаал. Улаанбаатар.
- Gonzalez, L. (2016, march). Green microfinance: a new frontier to inclusive financial services. *Revista de Administração de Empresas*, pp. <https://doi.org/10.1590/S0034-759020160209> .
- Australia, W. E. (2006). Principles of sustainable microfinance. Australia: World Education Australia.
- CGap. (2004). Key principles of microfinance. Washington: CGap.
- IFC (2014). Moving forward with ERMS: Findings from IFC Country Baseline Surveys
- Allet, M. (2011). Why do microfinance institutions go green?
- Allet, M. (2012). Measuring the environmental performance of microfinance: a new tool. *Cost management*.
- Forcella, D. (2014). Green Microfinance in Europe.
- Group, E.-M. M. (2016). Green Index 2.0: An Innovative tool to assess environmental performance in the microfinance sector .
- Passerelles, A. (2014). MFI's environmental performance in Central America under a context of climate change.
- Symbiotics. (2019). 2019 Symbiotics MIV Survey: Market data and peer group analysis.
- А.Одгэрэл, Т.-А. Б. (2020). Бичил санхүүгийн байгууллагын ногоон санхүүгийн өнөөгийн байдал судалгааны тайлан. КЗХТ.
- Хас банкны 2019 оны жилийн тайлан
- Хаан банкны 2019 оны жилийн тайлан
- Хаан банкны 2019 оны тогтвортой хөгжлийн тайлан

ХАВСРАЛТ

Ногоон индекс 2.0 аргачлалын чанарын үнэлгээний асуулга:

| | Ногоон бичил санхүү (чанарын үзүүлэлт) | (Тийм, Үгүй, Хэсэгчлэн) | Жинэлэх коэф |
|-----------------------|---|-------------------------|--------------|
| Стандарт 1 | Байгаль орчны стратегийг тодорхойлж, удирдаж, хянадаг эсэх | | |
| Үндсэн практик | Тухайн байгууллага байгаль орчны стратегиа тодорхойлсон эсэх | | |
| Үзүүлэлт | Тухайн байгууллага өөрийн эрхэм зорилго болон үнэт зүйлдээ байгаль орчныг хамгаалах талаар тусгадаг эсэх | | 0.2 |
| Үзүүлэлт | Тухайн байгууллага нь өөрийн байгаль орчны талаар баримтлах зорилго, зорилт болон гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтээ (indicators) тодорхойлж тусгасан байгаль орчны талаарх албан ёсны бодлоготой эсэх | | 0.2 |
| Үндсэн практик | Тухайн байгууллага байгаль орчны стратегиа удирдаж, хянадаг эсэх | | |
| Үзүүлэлт | Тухайн байгууллага нь хүрээлэн буй орчны асуудлыг хариуцсан хороо эсвэл ажилтныг томилдог эсэх | | 0.2 |
| Үзүүлэлт | Тухайн байгууллага байгаль орчны гүйцэтгэлийн үзүүлэлтүүдээ дотоод тайлангууд (ТУЗ, хөрөнгө оруулагчдад)-д тайлагнадаг эсэх | | 0.2 |
| Үзүүлэлт | Тухайн байгууллага байгаль орчны гүйцэтгэлийн үзүүлэлтүүдээ гадаад тайлангууд (олон нийтэд зориулан гаргадаг жилийн тайлангууд)-д тайлагнадаг эсэх | | 0.2 |
| Стандарт 2 | Байгаль орчны дотоод эрсдэлийг удирддаг эсэх | | |
| Үндсэн практик | Тухайн байгууллага нь байгаль орчны дотоод ул мөрийг багасгах ажиллагааг хийдэг эсэх | | |

| | | | |
|--------------------|---|--|------|
| Үзүүлэлт | Тухайн байгууллага нь төв болон салбарууддаа сэргээгдэх эрчим хүч ашиглах, хог хаягдлыг дахин боловсруулах /эсвэл эрчим хүч, ус, цаас, түлшний хэрэглээг бууруулах, хог хаягдлыг багасгах/ эсвэл хүлэмжийн хийг багасгах 2 буюу түүнээс дээш ажлуудыг хэрэгжүүлдэг эсэх | | 0.5 |
| Үндсэн практик | Төв болон салбар нэгжүүддээ эрчим хүч, ус, цаас, түлшний хэрэглээ болон хог хаягдал, хүлэмжийн хийг багасгахаар тогтоосон 2 буюу түүнээс дээш тоон зорилтдоо хүрч буй эсэхээ хянадаг эсэх | | 0.5 |
| Стандарт 3. | Байгаль орчны гадаад эрсдэлийг удирддаг эсэх | | |
| Үндсэн практик | Тухайн байгууллага нь харилцагчийн байгаль орчны эрсдэлийг үнэлдэг эсэх | | 0.25 |
| Үзүүлэлт | Тухайн байгууллага харилцагчийн үйл ажиллагаанаас үүсэх байгаль орчны эрсдэлийг үнэлэх тусгай арга хэрэгсэл ашигладаг эсэх | | |
| Үзүүлэлт | Тухайн байгууллага харилцагчийн үйл ажиллагаатай холбоотой байгаль орчны эрсдэлийг хэрхэн үнэлэх талаар зээлийн ажилтнаа сургадаг эсэх | | 0.25 |
| Үндсэн практик | Тухайн байгууллага харилцагчийн байгаль орчны эрсдэлийн түвшинг үнэлэх хүчин зүйлийг зээлийн бодлого, журамдаа оруулсан эсэх | | |
| Үзүүлэлт | Тухайн байгууллага зээлийн өргөдлийг байгаль орчны эрсдэлийн түвшингээр ангилж, эрсдэлийн ангилал тус бүрийн дагуу тусгай процедур хэрэгжүүлдэг эсэх | | 0.25 |
| Үндсэн практик | Тухайн байгууллага байгаль орчны эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг дэмждэг эсэх | | |
| Үзүүлэлт | Тухайн байгууллага харилцагчийн үйл ажиллагаатай холбоотой байгаль орчны эрсдэл болон түүнийг бууруулах стратегийн талаар таниулах үйл ажиллагаа зохион байгуулдаг эсэх | | 0.25 |
| Стандарт 4. | Ногоон боломжийг дэмжиж, урамшуулдаг эсэх | | |
| Үндсэн практик | Тухайн байгууллага байгаль орчинд ээлтэй цэвэр эрчим хүчинд (clean energy) зориулсан тусгай санхүүгийн бүтээгдэхүүн санал болгодог эсэх | | |

| | | | |
|----------------|--|--|-----|
| Үзүүлэлт | Тухайн байгууллага сэргээгдэх эрчим хүч эсвэл эрчим хүчний хэмнэлтэд зориулсан тусгай зээлийн бүтээгдэхүүнийг санал болгодог эсэх | | 0.2 |
| Үндсэн практик | Тухайн байгууллага тогтвортой эсвэл байгаль орчинд ээлтэй хөдөө аж ахуйд зориулсан тусгай санхүүгийн бүтээгдэхүүн санал болгодог эсэх | | |
| Үзүүлэлт | Тухайн байгууллага тогтвортой эсвэл байгаль орчинд ээлтэй хөдөө аж ахуйг (Climate-smart agriculture) дэмжих тусгай зээлийн эсвэл бусад санхүүгийн үйлчилгээ санал болгодог эсэх | | 0.2 |
| Үндсэн практик | Тухайн байгууллага бусад ногоон санхүүгийн эсвэл санхүүгийн бус бүтээгдэхүүн санал болгодог эсэх | | |
| Үзүүлэлт | Тухайн байгууллага байгаль орчинд ээлтэй үйл ажиллагааг дэмжихэд (сэргээгдэх эрчим хүч, эрчим хүчний хэмнэлттэй бүтээгдэхүүн, үйлчилгээ, дахин боловсруулалт, хог хаягдлын менежмент, цэвэр ус гэх мэт) зориулсан зээлийн бүтээгдэхүүн санал болгодог эсэх | | 0.2 |
| Үзүүлэлт | Тухайн байгууллага харилцагчдадаа байгаль орчны эрсдэлээс хамгаалах зорилго бүхий бичил даатгалын бүтээгдэхүүнийг шууд эсвэл гуравдагч талтай хамтран санал болгодог эсэх | | 0.2 |
| Үзүүлэлт | Тухайн байгууллага харилцагчиддаа өөрөө шууд эсвэл байгаль орчны байгууллагатай хамтрах замаар хэрхэн байгаль орчинд ээлтэй бизнес эрхлэх чиглэлээр сургалт явуулдаг эсэх | | 0.2 |

Дээрх чанарын үзүүлэлт тус бүрээр өгсөн үнэлгээнд харгалзах оноо жинэлэх коэффициентээр үржүүлж “ногоон индекс” буюу байгаль орчны гүйцэтгэлийн индексийг хэмжинэ. Энэхүү индекс нь хамгийн ихдээ 4.0 –р хэмжигдэх бөгөөд үүнээс гүйцэтгэлийн хувийг тодорхойлж болно. Тухайн санхүүгийн байгууллагын ногоон индексийг дээд утга болох 4.0 д харьцуулж гүйцэтгэлийн хувийг тодорхойлно.

$$[\Sigma \text{Ногоон индекс} = \text{Үнэлгээний оноо} \times \text{Жинэлэх коэф}]$$

Ногоон индекс 2.0 тоон үзүүлэлт:

Эдгээр үзүүлэлт нь бичил санхүүгийн байгууллагын ногоон санхүүжилтийн өнөөгийн нөхцөл байдал болон байгаль орчны гүйцэтгэлийг санхүүгийн үзүүлэлтүүдээр хэмжин харуулахад чиглэдэг.

| Стандарт | Үзүүлэлт | Тайлбар |
|------------|---|--|
| Стандарт 2 | Төв болон салбар нэгжүүдийн цахилгаан эрчим хүчний хэрэглээ (квт, мөнгөн дүнгээр) | <ul style="list-style-type: none"> • Үзүүлэлт тус бүрийн хувьд шинжилгээ нь нэг жилээс дээш хугацааны хандлагыг харуулахад анхаарах хэрэгтэй. • Бүх үзүүлэлтийн (FTE-full time equivalent staff) боломжит өөрчлөлтийг харуулдаг байх |
| | Төв болон салбар нэгжүүдийн усны хэрэглээ (м3, мөнгөн дүнгээр) | |
| | Төв болон салбар нэгжүүдийн цаасны хэрэглээ (кг эсвэл боодол, мөнгөн дүнгээр) | |
| | Төв болон салбар нэгжүүдийн шатахууны хэрэглээ (литр, мөнгөн дүнгээр) | |
| Стандарт 3 | Тайлант жилд хүлээн авсан зээлийн өргөдлийн тоо | <ul style="list-style-type: none"> • Зээлийн өргөдөлийн тоо болон мөнгөн дүнг харуулахад анхаарах |
| | Тайлант жилд байгаль орчин, нийгмийн өндөр эрсдэлтэй тул татгалзсан зээлийн өргөдлийн тоо | |
| | Байгаль орчны эрсдэлтэй гэж үнэлэгдсэн зээлийн үлдэгдлийн тоо | |
| Стандарт 4 | Ногоон бизнес/боломж/ болон технологийн талаарх мэдлэг тэлэх үйл ажиллагаа болон сургалтын үйл ажиллагааны тоо | <ul style="list-style-type: none"> • Нийт олгосон зээлийн тоонд эзлэх хувиар харуулж болно. |
| | Байгаль орчны эрсдлийн талаар мэдлэг тэлэх үйл ажиллагаа болон сургалтын үйл ажиллагааны тоо | |
| | Сэргээгдэх эрчим хүч, эрчим хүчний хэмнэлттэй төсөл, бүтээгдэхүүн, үйлчилгээг санхүүжүүлэхэд зориулж олгосон зээлийн хэмжээ (зээлийн тоо, мөнгөн дүнгээр) | |
| | Тогтвортой, цаг уурын ухаалаг шийдэл бүхий хөдөө аж ахуй (climate-smart agriculture)-н зориулалттай олгосон зээлийн хэмжээ (зээлийн тоо, мөнгөн дүнгээр) | |
| | Тайлангийн жилд олгосон бусад ногоон зээлийн бүтээгдэхүүний хэмжээ (зээлийн тоо, мөнгөн дүнгээр) | |
| | Хөдөө аж ахуйн болон цаг уурын бичил даатгалын гэрээтэй зээлдэгчийн тоо (зээлийн тоо, мөнгөн дүнгээр) | |

Энэхүү аргачлалын дагуу чанарын үзүүлэлт тус бүрээр үнэлгээ өгөхдөө Тийм, Үгүй, Хэсэгчлэн гэсэн 3 түвшинд хариулт өгнө.

Чанарын үзүүлэлт бүрээр өгсөн хариултыг тоон утга руу шилжүүлж гүйцэтгэлийн түвшинг хэмжихдээ “Үгүй буюу огт хэрэгжүүлдэггүй бол 0 оноо, Тийм, бүрэн хэрэгжүүлдэг бол 1 оноо, Хэсэгчлэн хэрэгжүүлдэг бол 0,5 оноо” өгөх замаар тоон утга руу шилжүүлнэ. **Хэсэгчлэн (Partially)** гэдэг үнэлгээг өгөхдөө тухайн санхүүгийн байгууллага нь ногоон индексийг хэмжих тухайн чанарын үзүүлэлтийг заримдаа хэрэгжүүлдэг эсвэл албан бус байдлаар хэрэгжүүлдэг байдлыг харгалзан үзнэ. Үзүүлэлт бүрээр “Тийм, Үгүй, Хэсэгчлэн” гэсэн үнэлгээг өгөхдөө дараах удирдамжийг ашиглахыг зөвлөж байна. Хэрэв тухайн санхүүгийн байгууллага чанарын 16 үзүүлэлт тус бүрээр “ТИЙМ” буюу бүрэн хэрэгжүүлдэг гэсэн үнэлгээ авсан бол үзүүлэлт тус бүрийг 1 оноогоор үнэлж тоон утга руу шилжүүлбэл нийт 16 оноо жинэлсэн утгаараа хамгийн ихдээ 4.0 гэсэн үнэлгээ авах болно.

Ногоон индекс 2.0 -Үнэлгээний асуулгыг бөглөх удирдамж

| Стандарт, шалгуур үзүүлэлтүүд | Ашиглах мэдээллийн эх сурвалж: |
|--|---|
| <p>Тухайн байгууллага өөрийн эрхэм зорилго болон үнэт зүйлдээ байгаль орчныг хамгаалах талаар тусгадаг эсэх</p> <p>Онооны удирдамж: Энэ асуултад эрхэм зорилго, алсын хараа, үнэт зүйл гэх 3 зүйлсийн аль нэгд нь “Байгаль орчин” гэдэг нэр томьёог тусгасан бол ТИЙМ гэж хариулна. Заавал гурвууланд нь байх албагүй. Дээрх 3 зүйлсийн аль нэгд нь “Нийгэм” гэх нэр томьёо багтсан тохиолдолд ХЭСЭГЧЛЭН гэж хариулах боломжтой.</p> | <p>Стратеги/бизнес төлөвлөгөө, вебсайт</p> |
| <p>Тухайн байгууллага нь өөрийн байгаль орчны талаар баримтлах зорилго, зорилт болон гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтээ (indicators) тодорхойлж тусгасан байгаль орчны талаарх албан ёсны бодлоготой эсэх</p> <p>Онооны удирдамж: Энэ асуултад албан ёсны, бичгээр үйлдсэн бодлоготой тохиолдолд ТИЙМ гэж хариулна. Хэрэв бодлого нь албан бус боловч үзүүлэлтүүд, зорилго, зорилт зэрэг нь тодорхой бөгөөд, байгууллага даяар мэддэг бол ХЭСЭГЧЛЭН гэж хариулах боломжтой.</p> | <p>Стратеги/бизнес төлөвлөгөө, Удирдлагын Мэдээллийн Системийн тайлан</p> |



| | |
|---|--|
| <p>Тухайн байгууллага нь хүрээлэн буй орчны асуудлыг хариуцсан хороо эсвэл ажилтныг томилдог эсэх</p> <p>Онооны удирдамж: Энэ асуултад ямар нэг хүн байгал орчны асуудалд ажлынхаа тодохой цагыг зориулдаг бол ТИЙМ гэж хариулна. Хэрэв албан бусаар хийдэг бөгөөд үүнийгээ нотолж чадвал ХЭСЭГЧЛЭН гэж хариулах боломжтой.</p> | <p>Гүйцэтгэх удирдлагатай хийх ярилцлага</p> |
| <p>Тухайн байгууллага байгаль орчны гүйцэтгэлийн үзүүлэлтүүдээ дотоод тайлангууд (ТУЗ, хөрөнгө оруулагчдад) болон гадаад тайлангууд (олон нийтэд зориулан гаргадаг жилийн тайлангууд)-д тайлагнадаг эсэх</p> <p>Онооны удирдамж: Энэ асуултад дотоод болон гадаад тайландаа байгал орчны гүйцэтгэлийн үзүүлэлтийг тогтмол тайлагнадаг тохиолдолд ТИЙМ гэж хариулна. Харин заримдаа, эсвэл ганцхан удаа тайлагнаж байсан бол ХЭСЭГЧЛЭН гэж хариулц болно.</p> | <p>Менежментийн тайлан, жилийн тайлан</p> |
| <p>Тухайн байгууллага нь төв болон салбарууддаа сэргээгдэх эрчим хүч ашиглах, хог хаягдлыг дахин боловсруулах /эсвэл эрчим хүч, ус, цаас, түлшний хэрэглээг бууруулах, хог хаягдлыг багасгах/ эсвэл хүлэмжийн хийг багасгах 2 буюу түүнээс дээш ажлуудыг хэрэгжүүлдэг эсэх</p> <p>Онооны удирдамж: Дээрхээс зөвхөн нэгээс олон ажлыг хэрэгжүүлдэг тохиолдолд ТИЙМ гэж хариулна. Хэрэв нэг л ажил хэрэгжүүлдэг бол ХЭСЭГЧЛЭН, албан ёсны зүйл байхгүй бол ҮГҮЙ гэж хариулна.</p> | <p>Бүх ажилчидтай хийх ярилцлага.</p> |
| <p>Төв болон салбар нэгжүүддээ эрчим хүч, ус, цаас, түлшний хэрэглээ болон хог хаягдал, хүлэмжийн хийг багасгахаар тогтоосон 2 буюу түүнээс дээш тоон зорилтдоо хүрч буй эсэхээ хянадаг эсэх</p> <p>Онооны удирдамж: Энэ асуултад заавал 2 ба түүнээс дээш үзүүлэлтийг хянадаг тохиолдолд ТИЙМ гэж хариулна. Хэрэв 1 л үзүүлэлтийг хянадаг эсвэл чанарын түвшинд хянадаг бол ХЭСЭГЧЛЭН гэж хариулна.</p> | <p>Экологийн ул мөрийн талаарх менежментийн тайлан</p> |

| | |
|--|---|
| <p>Тухайн байгууллага харилцагчийн үйл ажиллагаанаас үүсэх байгаль орчны эрсдэлийг үнэлэх тусгай арга хэрэгсэл ашигладаг эсэх</p> <p>Онооны удирдамж: Хэрэв зээл бүрийн эрсдлийг үнэлдэг бөгөөд бүлгийн зээлүүдэд зориулсан мэдээлэл өгөх үйл ажиллагаа явуулдаг бол ТИЙМ гэж хариулна. Хэрэв бүлгийн зээлүүдэд мэдээлэл хүргэх ажил хийдэггүй бол ХЭСЭГЧЛЭН гэж хариулна.</p> | <p>Стратеги/бизнес төлөвлөгөө, Удирдлагын Мэдээллийн Системийн тайлан</p> |
| <p>Тухайн байгууллага харилцагчийн үйл ажиллагаатай холбоотой байгаль орчны эрсдэлийг хэрхэн үнэлэх талаар зээлийн ажилтнаа сургадаг эсэх</p> <p>Онооны удирдамж: Хэрэв нийгмийн асуудалд байгал орчны асуудал багтдаг ба энэ талаар сургалт явуулдаг, үүнийгээ нотлох боломжтой тохиолдолд ХЭСЭГЧЛЭН хэмээн хариулж болно.</p> | <p>Сургалтын материалууд, Хүний Нөөцийн болон зээлийн мэргэжилтнүүдтэй хийсэн ярилцлага</p> |
| <p>Тухайн байгууллага зээлийн өргөдлийг байгаль орчны эрсдэлийн түвшингээр ангилж, эрсдэлийн ангилал тус бүрийн дагуу тусгай процедур хэрэгжүүлдэг эсэх</p> <p>Онооны удирдамж: Хэрэв танай бодлого зээлийн эрсдлийг үнэлж, ангилах тухай ба үүнийгээ үр дүнтэйгээр хэрэгжүүлж байгаа тохиолдолд ТИЙМ гэж хариулна. Хэрэв зээлийн өргөдлийг зөвхөн байгал орчны эрсдлийн түвшнээр ангилдаг боловч эрсдлийн ангилал тус бүрийн дагуу тодорхой журам хэрэгжүүлдэггүй бол ХЭСЭГЧЛЭН гэж хариулна.</p> | <p>Зээлийн бодлого, зээлийн хүсэлтийн маягт, салбарын менежер болон зээлийн ажилтантай хийсэн ярилцлага</p> |
| <p>Тухайн байгууллага харилцагчийн үйл ажиллагаатай холбоотой байгаль орчны эрсдэл болон түүнийг бууруулах стратегийн талаар таниулах үйл ажиллагаа зохион байгуулдаг эсэх</p> <p>Онооны удирдамж: Хэрэв танай байгууллага таниулах үйл ажиллагаа зохион байгуулдаг боловч тогтмол байхаар албажуулаагүй бол ХЭСЭГЧЛЭН гэж хариулах. Хэрэв таниулах үйл ажиллагаа нь эрсдлийн талаар бус байгал орчинд ээлтэй үйл ажиллагааны тухай бол ҮГҮЙ гэж хариулна.</p> | <p>Сургалтын материалууд, Хүний Нөөцийн болон зээлийн мэргэжилтнүүдтэй хийсэн ярилцлага</p> |



| | |
|--|---|
| <p>Тухайн байгууллага сэргээгдэх эрчим хүч эсвэл эрчим хүчний хэмнэлтэд зориулсан тусгай зээлийн бүтээгдэхүүнийг санал болгодог эсэх</p> <p>Онооны удирдамж: ТИЙМ гэж хариулахад дээрх технологиудаас зөвхөн аль нэгд нь л зориулсан зээлийн бүтээгдэхүүн санал болгодог байхад хангалттай. Тусгай зээлийн бүтээгдэхүүн байхгүй ч сэргээгдэх эрчим хүч, эрчим хүчний хэмнэлтэд зориулсан зээл олгож байсан ба үүнийгээ жишээгээр нотолж чадвал ХЭСЭГЧЛЭН гэж хариулна.</p> | <p>Бүтээгдэхүүний танилцуулга, салбарын менежер болон зээлийн ажилтантай хийсэн ярилцлага</p> |
| <p>Тухайн байгууллага тогтвортой эсвэл байгаль орчинд ээлтэй хөдөө аж ахуйг (Climate-smart agriculture) дэмжих тусгай зээлийн эсвэл бусад санхүүгийн үйлчилгээ санал болгодог эсэх</p> <p>Онооны удирдамж: ТИЙМ гэж хариулахын тулд санхүүгийн бүтээгдэхүүнүүд нь тогтвортой, цаг уурын ухаалаг (climate-smart) хөдөө аж ахуйг дэмжих тодорхой зорилготой байх ёстой. Тогтвортой эсвэл цаг уурын ухаалаг ХАА-н аль нэгийг дэмжсэн үйлчилгээ санал болгодог бол ТИЙМ гэж хариулна, заавал аль аль нь байх албагүй.</p> | <p>Бүтээгдэхүүний танилцуулга, салбарын менежер болон зээлийн ажилтантай хийсэн ярилцлага</p> |
| <p>Тухайн байгууллага байгаль орчинд ээлтэй үйл ажиллагааг дэмжихэд (сэргээгдэх эрчим хүч, эрчим хүчний хэмнэлттэй бүтээгдэхүүн, үйлчилгээ, дахин боловсруулалт, хог хаягдлын менежмент, цэвэр ус гэх мэт) зориулсан зээлийн бүтээгдэхүүн санал болгодог эсэх</p> <p>Онооны удирдамж: Хэрэв танай байгууллага дээрх үйл ажиллагааг санхүүжүүлдэг боловч тусгай зээлийн бүтээгдэхүүн байхгүй ч ерөнхий зээлийн бүтээгдэхүүнээр дамжуулан (ажлын капитал, хөрөнгө оруулалт г.м) санхүүжүүлдэг бөгөөд үүнийг нотлох боломжтой бол ХЭСЭГЧЛЭН гэж хариулна.</p> | <p>Бүтээгдэхүүний танилцуулга, салбарын менежер болон зээлийн ажилтантай хийсэн ярилцлага</p> |

| | |
|--|---|
| <p>Тухайн байгууллага харилцагчдадаа байгаль орчны эрсдэлээс хамгаалах зорилго бүхий бичил даатгалын бүтээгдэхүүнийг шууд эсвэл гуравдагч талтай хамтран санал болгодог эсэх</p> <p>Онооны удирдамж: Даатгалын бүтээгдэхүүн нь тусгайлан цаг уур, ХАА-н эрсдлийг хариуцдаг байх нь чухал. Хэрэв тусгайлсан ийм даатгалын бүтээгдэхүүн биш бол ҮГҮЙ гэж хариулна.</p> | <p>Бүтээгдэхүүний танилцуулга, салбарын менежер болон зээлийн ажилтантай хийсэн ярилцлага</p> |
| <p>Тухайн байгууллага харилцагчиддаа өөрөө шууд эсвэл байгаль орчны байгууллагатай хамтрах замаар хэрхэн байгаль орчинд ээлтэй бизнес эрхлэх чиглэлээр сургалт явуулдаг эсэх</p> <p>Онооны удирдамж: Хэрэв танай байгууллага тусгай сургалтын үйл ажиллагаа байхгүй ч ерөнхий сургалтын агуулгад тодорхой хэмжээнд байгал орчны хэсэг багтдаг, үүнийгээ нотлох боломжтой бол ХЭСЭГЧЛЭН гэж хариулна.</p> | <p>Сургалтын материалууд, Харилцагчидтай хийсэн ярилцлага</p> |

Жишээ-Ногоон индексийн тооцооллт

Жишээлбэл, “AAA” ББСБ хувьд байгаль орчны гүйцэтгэлийг дараах байдлаар үнэлсэн гэж үзээд “AAA” ББСБ-ийн ногоон индексийг тооцоолж үзье.

| | Ногоон бичил санхүү (чанарын үзүүлэлт) | Үнэлгээ | Жинэлэх коэф | Индекс |
|-----------------------|---|---------|--------------|--------|
| Стандарт 1 | Байгаль орчны стратегийг тодорхойлж, удирдаж, хянадаг эсэх | | | |
| Үндсэн практик | Тухайн байгууллага байгаль орчны стратегиа тодорхойлсон эсэх | | | |
| Үзүүлэлт | Тухайн байгууллага өөрийн эрхэм зорилго болон үнэт зүйлдээ байгаль орчныг хамгаалах талаар тусгадаг эсэх | 0.5 | 0.2 | 0.1 |
| Үзүүлэлт | Тухайн байгууллага нь өөрийн байгаль орчны талаар баримтлах зорилго, зорилт болон гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтээ (indicators) тодорхойлж тусгасан байгаль орчны талаарх албан ёсны бодлоготой эсэх | 0 | 0.2 | 0 |



| | | | | |
|-----------------------|---|-----|------|-------|
| Үндсэн практик | Тухайн байгууллага байгаль орчны стратегиа удирдаж, хянадаг эсэх | | | |
| Үзүүлэлт | Тухайн байгууллага нь хүрээлэн буй орчны асуудлыг хариуцсан хороо эсвэл ажилтныг томилдог эсэх | 0 | 0.2 | 0 |
| Үзүүлэлт | Тухайн байгууллага байгаль орчны гүйцэтгэлийн үзүүлэлтүүдээ дотоод тайлангууд (ТУЗ, хөрөнгө оруулагчдад)-д тайлагнадаг эсэх | 0.5 | 0.2 | 0.1 |
| Үзүүлэлт | Тухайн байгууллага байгаль орчны гүйцэтгэлийн үзүүлэлтүүдээ гадаад тайлангууд (олон нийтэд зориулан гаргадаг жилийн тайлангууд)-д тайлагнадаг эсэх | 0 | 0.2 | 0 |
| Стандарт 2 | Байгаль орчны дотоод эрсдэлийг удирддаг эсэх | | | |
| Үндсэн практик | Тухайн байгууллага нь байгаль орчны дотоод ул мөрийг багасгах ажиллагааг хийдэг эсэх | | | |
| Үзүүлэлт | Тухайн байгууллага нь төв болон салбарууддаа сэргээгдэх эрчим хүч ашиглах, хог хаягдлыг дахин боловсруулах /эсвэл эрчим хүч, ус, цаас, түлшний хэрэглээг бууруулах, хог хаягдлыг багасгах/ эсвэл хүлэмжийн хийг багасгах 2 буюу түүнээс дээш ажлуудыг хэрэгжүүлдэг эсэх | 0.5 | 0.5 | 0.25 |
| Үндсэн практик | Тухайн байгууллага нь дотоод экологийн ул мөрийг хянадаг эсэх | | | |
| Үзүүлэлт | Төв болон салбар нэгжүүддээ эрчим хүч, ус, цаас, түлшний хэрэглээ болон хог хаягдал, хүлэмжийн хийг багасгахаар тогтоосон 2 буюу түүнээс дээш тоон зорилтдоо хүрч буй эсэхээ хянадаг эсэх | 0.5 | 0.5 | 0.25 |
| Стандарт 3. | Байгаль орчны гадаад эрсдэлийг удирддаг эсэх | | | |
| Үндсэн практик | Тухайн байгууллага нь харилцагчийн байгаль орчны эрсдэлийг үнэлдэг эсэх | | | |
| Үзүүлэлт | Тухайн байгууллага харилцагчийн үйл ажиллагаанаас үүсэх байгаль орчны эрсдэлийг үнэлэх тусгай арга хэрэгсэл ашигладаг эсэх | 0.5 | 0.25 | 0.125 |

| | | | | |
|-----------------------|---|-----|------|-------|
| Үзүүлэлт | Тухайн байгууллага харилцагчийн үйл ажиллагаатай холбоотой байгаль орчны эрсдэлийг хэрхэн үнэлэх талаар зээлийн ажилтнаа сургадаг эсэх | 0.5 | 0.25 | 0.125 |
| Үндсэн практик | Тухайн байгууллага харилцагчийн байгаль орчны эрсдэлийн түвшинг үнэлэх хүчин зүйлийг зээлийн бодлого, журамдаа оруулсан эсэх | | | |
| Үзүүлэлт | Тухайн байгууллага зээлийн өргөдлийг байгаль орчны эрсдэлийн түвшингээр ангилж, эрсдэлийн ангилал тус бүрийн дагуу тусгай процедур хэрэгжүүлдэг эсэх | 0.5 | 0.25 | 0.125 |
| Үндсэн практик | Тухайн байгууллага байгаль орчны эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг дэмждэг эсэх | | | |
| Үзүүлэлт | Тухайн байгууллага харилцагчийн үйл ажиллагаатай холбоотой байгаль орчны эрсдэл болон түүнийг бууруулах стратегийн талаар таниулах үйл ажиллагаа зохион байгуулдаг эсэх | 0 | 0.25 | 0 |
| Стандарт 4. | Ногоон боломжийг дэмжиж, урамшуулдаг эсэх | | | |
| Үндсэн практик | Тухайн байгууллага байгаль орчинд ээлтэй цэвэр эрчим хүчинд (clean energy) зориулсан тусгай санхүүгийн бүтээгдэхүүн санал болгодог эсэх | | | |
| Үзүүлэлт | Тухайн байгууллага сэргээгдэх эрчим хүч эсвэл эрчим хүчний хэмнэлтэд зориулсан тусгай зээлийн бүтээгдэхүүнийг санал болгодог эсэх | 0.5 | 0.2 | 0.1 |
| Үндсэн практик | Тухайн байгууллага тогтвортой эсвэл байгаль орчинд ээлтэй хөдөө аж ахуйд зориулсан тусгай санхүүгийн бүтээгдэхүүн санал болгодог эсэх | | | |
| Үзүүлэлт | Тухайн байгууллага тогтвортой эсвэл байгаль орчинд ээлтэй хөдөө аж ахуйг (Climate-smart agriculture) дэмжих тусгай зээлийн эсвэл бусад санхүүгийн үйлчилгээ санал болгодог эсэх | 0 | 0.2 | 0 |



| Үндсэн практик | Тухайн байгууллага бусад ногоон санхүүгийн эсвэл санхүүгийн бус бүтээгдэхүүн санал болгодог | | | |
|----------------|--|----------|----------|--------------|
| Үзүүлэлт | Тухайн байгууллага байгаль орчинд ээлтэй үйл ажиллагааг дэмжихэд (сэргээгдэх эрчим хүч, эрчим хүчний хэмнэлттэй бүтээгдэхүүн, үйлчилгээ, дахин боловсруулалт, хог хаягдлын менежмент, цэвэр ус гэх мэт) зориулсан зээлийн бүтээгдэхүүн санал болгодог эсэх | 0 | 0.2 | 0 |
| Үзүүлэлт | Тухайн байгууллага харилцагчдадаа байгаль орчны эрсдэлээс хамгаалах зорилго бүхий бичил даатгалын бүтээгдэхүүнийг шууд эсвэл гуравдагч талтай хамтран санал болгодог эсэх | 0 | 0.2 | 0 |
| Үзүүлэлт | Тухайн байгууллага харилцагчиддаа өөрөө шууд эсвэл байгаль орчны байгууллагатай хамтрах замаар хэрхэн байгаль орчинд ээлтэй бизнес эрхлэх чиглэлээр сургалт явуулдаг эсэх | 0 | 0.2 | 0 |
| | Нийт индекс | 4 | 4 | 1.175 |

Үнэлгээгээр “AAA” ББСБ-ийн байгаль орчны гүйцэтгэлийн ногоон индекс 1.175 буюу 29.4 хувь (1.175/4) байна. Стандарт тус бүрийн гүйцэтгэл дараах байдалтай байна.

| Стандарт | Стандартын тодорхойлолт | Авах ёстой индекс | Гүйцэтгэлийн индекс | Гүйцэтгэлийн хувь |
|-------------|--|-------------------|---------------------|-------------------|
| Стандарт 1 | Байгаль орчны стратегийг тодорхойлж, удирдаж, хянадаг эсэх | 1 | 0.2 | 20.0% |
| Стандарт 2 | Байгаль орчны дотоод эрсдэлийг удирддаг эсэх | 1 | 0.2 | 50.0% |
| Стандарт 3. | Байгаль орчны гадаад эрсдэлийг удирддаг эсэх | 1 | 0.375 | 37.5% |
| Стандарт 4. | Ногоон боломжийг дэмжиж, урамшуулдаг эсэх | 1 | 0.1 | 10.0% |
| | НИЙТ ИНДЕКС/ ГҮЙЦЭТГЭЛИЙН ХУВЬ | 4 | 1.175 | 29.4% |

